

**“ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ”**

ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2017 он

Улаанбаатар хот

1. Хураангуй
2. Товчилсон үгийн жагсаалт
3. Хавсралтын жагсаалт
4. Удиртгал
5. Танилцуулга
6. Судалгааны зорилго
7. Судалгааны арга зүй
8. ХХГХ-ийн Монгол дахь нөхцөл байдал
9. Эрх зүйн орчин
 - Олон улсын эрх зүйн баримт бичгүүд
 - Бүс нутгийн эрх зүйн баримт бичгүүд
 - Олон талт болон хоёр талын хамтын гэрээ
 - Үндэсний эрх зүйн баримт бичгүүд баХХГХтТХ-ийг шүүхийн практикт хэрхэн хэрэглэж байгаад хийсэн дүн шинжилгээ
10. Монгол дахь үндэсний сүлжээ, хэрэгжүүлэгч байгууллага
 - Төрийн байгууллага бүтэц, механизм
 - ТББ
 - Олон талт хамтын ажиллагааны хандлага үйл ажиллагааг зохицуулах
11. Хохирогчийг тогтоох, хамгаалах, гэмт хэрэгтэнд хариуцлага оногдуулах
 - Хохирогчийг тогтоох
 - Мөрдөн шалгах
 - Нотлох баримт цуглуулах
 - Сэжигтнээс мэдүүлэг авах
 - Гэрч хохирогчийг хамгаалах
12. Олон улсын хамтын ажиллагаа
13. Хэрэгцээг үнэлэх
 - ХХГХ-ийн орчинд гарч буй шинэ хандлага
 - Хохирогч тогтоох, зуучлан туслах хамгаалахад тулгарч буй шийдвэрлэгдээгүй асуудлууд
 - ХХГХ-тэй тэмцэж буй байгууллага хоорондын хамтын ажиллагаа
14. Зөвлөмж
15. Дүгнэлт
16. Ном зүй
17. Хавсралт

1. ХУРААНГУЙ

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль	
Хуулийн зохицуулалт	Хэрэгжилтийн байдал
3.1.2.“Хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг хэлнэ.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь эрүүгийн хэрэгт хохирогчоор тогтоогдоогүй бол Гэрч, хохирогчийг хамгаалах тухай болон Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд заасан хамгаалалтыг авах боломжгүй байна. Учир нь ЭХШХШтХууль болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулинд хохирогчоор тогтоосон байхыг шаардсан заалт үйлчилж байгаа учраас ХХТХ-ийн 3.1.2-т заасан хохирогчдын талаархи заалт хэрэгжих боломжгүй байна.
5.1.3.Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх.	Төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллах хүрээ, санхүүжилт жилээс жилд тодорхой хэмжээнд өссөн боловч энэхүү түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний дийлэнх хувийг байнгын бус нэг удаагийн шинжтэй гарын авлага, мэдээлэл боловсруулах, сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа эзэлж байна. Харин Иргэдийг ХХГХ-с урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хамруулах, хамгаалах байрыг тогтмол ажиллуулах, хууль зүй, нийгэм сэтгэл зүйн туслалцаа гэх зэрэг хохирогчид нэн чухал хэрэгцээтэй үйлчилгээг тогтмол болгоход төрөөс ТББ-тай хамтран ажиллах санаачлага дутмаг, гэрээгээр ажил гүйцэтгүүлэх явдал хангалтгүй байна.
5.2.3.Улсын ерөнхий прокурортой хамтран хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам батлах.	ХЗДХЯ-аас батлан мөрдүүлэх “Хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх, хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах” ЭМЯ-аас батлан гаргах “ХХГХ-ийн хохирогчид эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх” журмууд батлагдан гараагүй байна. Эдгээр журмууд нь 2013 онд батлагдан гарах ёстой байсан боловч 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдсөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмуудтай давхардсан гэдэг үндэслэлээр нийтлэг байдлаар гэмт хэргийн хохирогчид үйлчлэх журамд багтаан зохицуулж байна.
5.3.1.Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан олон улсын гэрээнд нэгдэн орох санал боловсруулах, энэ талаар гадаад улс, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр хийх, нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;	Монгол Улс нь 2016 оны байдлаар нийт 28 төрлийн эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг байгуулсан байна. Тэдгээрээс иргэний хэргээр 17 улстай, эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг 17 улстай, гэмт этгээдийг шилжүүлэх тухай гэрээг 17 улстай, ялтан шилжүүлэх тухай гэрээг 9 улстай тус тус байгуулжээ. Гэвч Монгол Улсын иргэд ихээр зорчих болсон, мөн хил дамжуулан худалдаалах гэмт хэрэг ихээр гардаг Малайз, Сингапур, Хонконг, Тайланд, Филиппин, Макао зэрэг улс орнуудтай өнөөг хүртэл эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээгүй хэвээр байна.
5.6.2.Хүн худалдаалахын хор уршиг, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, тайлбарлан таниулах талаар ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөр, стандартад тусгах.	Боловсролын багц хуульд энэ чиглэлээр тодорхой заалт байхгүй, өнөөг хүртэл суурь болон бүрэн дунд

		боловсролын сургалтын хөтөлбөрт энэ чиглэлээр агуулга тусгагдаагүй байна.
5.9.Мэргэжлийн хяналтын байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсадыг албадан хөдөлмөр, боолчлол, боолчлолтой ижил төстэй нөхцөлд ажиллуулж, байлгаж байгаа эсэхэд өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавина.		Энэ ажил хангалттай хийгддэггүй бөгөөд энэ чиглэлийн хяналт сул, хяналтыг хэрэгжүүлэгч мэргэжилтнүүд бэлтгэгдээгүй байна. Хөдөлмөрийн мөлжлөгийн хувьд илрүүлэлт хангалтгүй, иргэдийн дунд ойлголт мэдлэг муугаас хохирогч болох, энэ талаар хуулийн байгууллагад мэдээлэхгүй байх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, хувийн аж ахуйн нэгж, компани, хувиараа аж ахуй эрхлэгчид, малчид зэрэг хөдөлмөрийн дийлэнх салбарт бусдын хөдөлмөрийг хууль бусаар ашиглах явдал түгээмэл байсаар байна.
5.12.Бүх шатны нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.12.1.нутаг дэвсгэртээ хүн худалдаалахтай тэмцэх, шалтгаан нөхцөлийг нь тогтоож арилгах арга хэмжээ авах; 5.12.2.хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; 5.12.3.хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах 5.12.4.хүн худалдаалахтай холбоотой байж болзошгүй зар сурталчилгаанд харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хяналт тавих.		Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт орон нутагт туйлын хангалтгүй байна. Ялангуяа энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт, хохирогчид үзүүлэх үйлчилгээ хийгддэггүй. Аймгуудад ГХУС Зөвлөл дахин үйл ажиллагаагаа шинээр эхлэн ажиллаж байгаа хэдий ч бүрэн тогтворжоогүй байна. Сумдын түвшинд үйл ажиллагаа тогтвортой биш зарим сумдад зөвхөн ОУ-ын байгууллагын дэмжлэгээр төслийн хүрээнд урьдчилан сэргийлэх ажил хийгдэж байна. Жишээлбэл: ОУШХБ-ын дэмжлэгээр Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-овоо, Манлай, Ханбогд Дорноговь аймгийн Замын-Үүд зэрэг сумдад ХХГХ-с урьдчилан сэргийлэх ажлыг 2014 оноос хойш тогтмол хийж байна.
6 дугаар зүйл.Дэд зөвлөл, түүний бүрэн эрх 6.6.2.хүн худалдаалах нөхцөл байдлын талаар мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагаар судалгаа хийлгэх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөр уламжлан Засгийн газарт оруулах; 6.6.6.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтныг энэ хуулийн 16.5–д заасан журмын дагуу урамшуулах арга хэмжээ авах; 6.6.7.хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгуулах талаар санал боловсруулах;		Хууль хэрэгжиж эхэлснээс хойш ГХУСЗ болон түүний Дэд зөвлөлөөс хүн худалдаалахтай тэмцэх чиглэлийн үйл ажиллагаа болон цаашид авах арга хэмжээг Засгийн газарт танилцуулсан тохиолдол байхгүй байна. Иргэн аж ахуйн нэгж, албан тушаалтныг урамшуулах арга хэмжээ авагдаагүй байна.
6.6.8.хүн худалдаалах, түүний хор уршгийн талаарх нэгдсэн мэдээг гаргах;		Энэ чиглэлээр хийгдсэн мэдээ, судалгаа байхгүй
6.6.9.хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээний стандартын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;		Энэ чиглэлээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тохиолдол байхгүй байна.
7.2.Хуулийн этгээд нь үйл ажиллагааныхаа халхавчин дор хүн худалдаалах үйл ажиллагаа явуулсан нь		Хуулийн этгээдийг татан буулгах арга хэмжээг авсан тохиолдол бүртгэгдээгүй байна.

<p>тогтоогдвол тухайн хуулийн этгээдийг шүүхийн шийдвэрээр татан буулгана.</p>	
<p>12.1.Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ: 12.1.1.эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ; 12.1.2.сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ; 12.1.3.ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах; 12.1.4.хууль зүйн туслалцаа; 12.3.Энэ хуулийн 12.1-д заасан хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ үнэ төлбөргүй байна.</p>	<p>Хохирогчид үзүүлэх үйлчилгээ хангалттай бус, зарим төрлийн үйлчилгээ үзүүлэх журам батлагдсан боловч хөрөнгө төсөвлөгдөөгүй тул хэрэгждэггүй байна.</p> <p>Хохирогчид үзүүлэх хууль зүйн туслалцааны хувьд өнөөг хүртэл холбогдох журмыг батлаагүй, зөвхөн ТББ-ын нөөцөөр хязгаарлагдмал хүрээнд, сайн дурын шинжтэй хэрэгжиж байна. 12.3 дугаар заалт огт хэрэгждэггүй.</p>
<p>15 дугаар зүйл.Хохирол нөхөн төлүүлэх</p> <p>15.1.Хохирогч нь эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй.</p> <p>15.2.Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө.</p> <p>15.3.Хохирогчийн сэтгэл санааны хохирлын хэмжээг түүний нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хохирогчид учирсан гэм хорын хэр хэмжээг харгалзан шүүх тогтооно.</p>	<p>Хохирогчид учирсан амь нас, эд хөрөнгө, бие махбодь, сэтгэл санааны хохирлыг үнэлэх, барагдуулах, нөхөн төлүүлэх, нөхөн сэргээх талаар хуульд заасан ч Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Иргэний хуульд бүрэн хуульчлаагүйгээс хохирогчийн амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлыг үнэлж, нөхөн төлүүлсэн практик байхгүй, энэ зохицуулалт бүрэн хэрэгжих боломжгүй байна.</p>
<p>16 дугаар зүйл.Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны санхүүжилт</p> <p>16.1.Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:</p> <p>16.1.2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1-д заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал;</p> <p>16.3.Энэ хуулийн 16.1-д заасан хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулна:</p> <p>16.3.1.энэ хуулийн 9.1-д заасан хамгаалах байрны үйл ажиллагааг санхүүжүүлэх;</p> <p>16.3.4.хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтныг урамшуулах;</p> <p>16.5.Энэ хуулийн 16.3.4-т заасан урамшуулал олгох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан санхүүжилтийг зарцуулах зохицуулалтын зөрүүнээс хамаарч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас ХХГХ-ийн хохирогчийг хамгаалан байрлуулах үйлчилгээг санхүүжүүлэх боломжгүй болж байна.</p> <p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтныг урамшуулах журам батлагдан гараагүй тул энэ арга хэмжээ өнөөг болтол хэрэгждэггүй байна.</p>
<p>17 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага</p>	<p>Энэ хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул, мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа хангалтгүй байдлаас хамаарч энэ хуулийг зөрчсөн зөрчлийг илрүүлсэн, арга хэмжээ авсан тохиолдол байхгүй байна.</p>

<p>17.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>17.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p><i>/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i></p>	
---	--

2. ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:

- УИХ - Улсын Их Хурал
- ЗГ - Засгийн Газар
- ХЗДХЯ - Хууль Зүй Дотоод Хэргийн Яам
- ЭМЯ - Эрүүл Мэндийн Яам
- НХХЯ - Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам
- БСШУСЯ - Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам
- ГХЯ - Гадаад Хэргийн Яам
- ХХЕГ - Хил Хамгаалах Ерөнхий Газар
- УДШ - Улсын Дээд Шүүх
- УЕПГ - Улсын Ерөнхий Прокурорын Газар
- ЦЕГ - Цагдаагийн Ерөнхий Газар
- ЭЦГ - Эрүүгийн Цагдаагийн Газар
- ГИХГ - Гадаадын Иргэн, Харьяатын Газар
- МХЕГ - Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
- ТЕГ - Тагнуулын Ерөнхий Газар
- НҮБ - Нэгдсэн Үндэсний Байгууллага
- ОУШХБ - Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага
- ХЭЗ - Хүний Эрхийн Зөвлөл
- ХАБСТ - Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төв ТББ
- ХТЭТ - Хүйсийн Тэгш Эрхийн Төв ТББ
- ХЭХТ - Хүний Эрх Хөгжил Төв ТББ
- ЭБШХ - Эрүүгийн Байцаан Шийтгэх Хууль
- ИХШХШТХ - Иргэний Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх Тухай Хууль
- ХХТТХ - Хүн Худалдаалахтай Тэмцэх Тухай Хууль
- ХХГХ - Хүн Худалдаалах Гэмт Хэрэг
- ЭБША - Эрүүгийн Байцаан Шийтгэх Ажиллагаа

3. ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ:

Монгол Улсын хууль тогтоомж, хөтөлбөр

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Эрүүгийн хууль
3. Эрүүгийн хууль/ Шинэчилсэн найруулга/
4. Эрүүгийн байцаан шийтгэх хууль
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
6. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
7. Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль
8. Хөдөлмөрийн хууль
9. Донорын тухай хууль
10. 2016-2020 онд хэрэгжүүлэх ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр

Олон улсын эрх зүйн баримт бичиг

1. НҮБ-ын үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол
2. Хүүхдийн эрхийн тухай конвенци
3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
4. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын Конвенци
5. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай конвенци
6. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулсан нэмэлт протокол
7. Албадан хөдөлмөрийн эрхлэлтийн тухай 29-р конвенци
8. Албадан хөдөлмөрийн эрхлэлтийн эсрэг 105 –р конвенци
9. НҮБ-ын ХЭЗ-ийн зөвлөмжүүд

Судалгааны тайлан гарын авлага

1. Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал ба арга зам 2006 он, ХЭХТ

2. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдуулан хийсэн судалгаануудын товч эмхтгэл, 2011 он, ХАБСТ
3. С.Дондов, Ч.Түмэнбаяр, Хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар ажилладаг хуульчдад зориулсан гарын авлага, 2009 он, ХЭХТ
4. С.Дондов, Ж.Батзаяа, Б.Энхцэцэг, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглах гарын авлага, 2015 он ,ХАБСТ
5. П.Оюунчимэг, Хүн худалдаалах гэмт хэрэг, 2011 он, ХЭҮК
6. С.Гантулга, Хүн худалдаалах гэмт хэрэг, 2013 он ,
7. ХХГХ-ийн асуудлаар ажилладаг ТБ, ТББ-ын ажилтнуудтай ярилцсан Ярилцлагын тэмдэглэл, 2017 он
8. ИТХЭТ-с яамд, төрийн байгууллагад 2017 оны 1-3 сард явуулсан тоотын хариу
9. Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны өртөг судалгаа, ХТЭТ ТББ 2016 он
10. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд мониторинг, 2014 он Эмэгтэй удирдагч сан
11. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан болон батлах шаардлагатай байгаа журмуудад хийсэн дүн шинжилгээ, 2015 он Хүний эрх, хөгжил төв

4. УДИРТГАЛ:

Энэхүү судалгааг Европын Холбооны Ардчилал ба Хүний Эрх Байгууллагын дэмжлэгтэйгээр Европын Холбооноос санхүүжүүлж буй "Шилжин суурьшигчийн эрхийг хамгаалах нь" төслийн хүрээнд Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагын захиалгаар Иргэдэд Туслах Хүний Эрхийн Төвийн Тэргүүн, Өмгөөлөгч хатагтай Дондов хийсэн болно. Энэ ажлын үндсэн зорилго нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжийн тал дээр дүн шинжилгээ хийж, үр дүнд нь үндэслэн Монгол улсад хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг боловсронгуй болгох зөвлөмж гаргах юм. Зөвлөмжийг Засгийн газар болон бусад оролцогч байгууллагуудад зориулна.

Энэ хоёр жилийн хугацаатай төслийн /2016-2018/ гол зорилго нь шилжин суурьшигчид болон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээг сайжруулахад Монгол улсын иргэний нийгмийн чадавхийг сайжруулах, шилжин суурьшигчид, хүний наймааны хохирогчдод тусламж дэмжлэг үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх, хүний наймаа болон хүний эрхийн зөрчлүүдтэй тэмцэгч байгууллага, мэргэжилтнүүдийг чадавхижуулах юм.

5. ТАНИЛЦУУЛГА:

Иргэдэд туслах хүний эрхийн төв нь Хүн худалдаалахтай тэмцэх асуудлаар иргэд, хуульчдын мэдлэг нэмэгдүүлэх сургалтууд зохион байгуулах, гарын авлага боловсруулах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод хууль зүйн туслалцаа үзүүлэх зэрэг үйл ажиллагааг явуулж байна. Тус байгууллага нь Хүний наймааны эсрэг төрийн бус байгууллагуудын сүлжээний гишүүн байгууллага юм.

Энэ удаа Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагын дэмжлэгээр хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийлээ.

Гэрээт ажлыг 2016 оны 12 сараас 2017 оны 7 сарын хооронд тус төвийн тэргүүн, өмгөөлөгч С.Дондов хийж гүйцэтгэлээ.

6. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж түүний үр дүнд үндэслэн Монгол улсад хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах зөвлөмж боловсруулан гаргах юм.

- ХХГХ-ийн асуудлаар Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын болон дотоодын эрх зүйн актуудыг судлах тэдгээр хууль, журмуудад энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах, хариуцлага тооцох механизмыг хуульчилсан байдал хууль, журмуудыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн Газраас хувиарласан санхүүжилт, амлалтанд хяналт тавих систем зэргийг судлах
- ХХГХ-ийн хохирогчдыг тогтоох, эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлж буй үйлчилгээний өнөөгийн тогтолцооны байдалд дүн шинжилгээ хийх
- 2012 онд батлагдсан Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд ХХГХ-ийн эсрэг Дэд зөвлөлийн хийж гүйцэтгэсэн ажил, анхаарах зүйлийн талаар дүгнэлт өгөх
- ХХГХ-тэй тэмцэхэд иргэний нийгмийн гүйцэтгэж буй хувь нэмэр, хохирогчдод үзүүлж буй туслалцаа, бусад хамтын ажиллагаа, үүрэг хариуцлагын талаар хууль тогтоомжоор хэрхэн зохицуулсныг үнэлэн үзэх
- ХХГХ-ийн эсрэг хуулийн хэрэгжилт хэрхэн хэрэгжиж байгаа талаархи дүгнэлтэнд үндэслэн цаашид сайжруулах зорилгоор Засгийн газарт зөвлөмж

өгч танилцуулах. Энэхүү зөвлөмж нь бусад хамтрагч талуудын ХХГХ-тэй тэмцэх үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн байна.

7. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ:

- Баримт бичигт дүн шинжилгээ хийхдээ урьд өмнө хийгдсэн судалгаа, олон улсын гэрээ конвенциуд, хуулиуд, холбогдох дүрэм журмуудыг судаллаа.
- Хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар ажилладаг Төрийн болон ТББ-дын ажилтнуудыг оролцуулсан фокус бүлгийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж төрийн болон ТББ-ын ажилтнуудтай ганцаарчилсан ярилцлагуудыг хийсэн болно.
- Судлаачийн өмгөөлөгчөөр ажиллаж шийдвэрлэгдсэн хэргүүд болон ХТЭТ-ийн хийсэн судалгааг тохиолдол шинжлэхдээ эх сурвалж болгон ашиглав.
- Тоо мэдээ цуглуулахдаа ХЗДХЯ, ХНХЯ, ЦЕГ, ЭЦГ зэрэг төрийн байгууллагуудаас гадна ХХГХ-ийн асуудлаар тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-ын мэдээллийг ашигласан болно.

8. МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:

Хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг нь бусдын биеийг нь үнэлүүлэн бэлгийн харилцаанд оруулан мөлжих, албадан ажиллуулж үйлчлүүлэх, боолчлох буюу эрх чөлөөгүй байлгах, эд, эрхтэнийг нь авах зэрэг зорилгоор хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглан хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл өөр этгээдийг хяналтандаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийх, ашиг олгон хахуульдах замаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуух буюу хүлээн авах үйлдлийг хэлнэ.


Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх, хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэн сайжирч байгаа боловч хуульчдын дунд хүн худалдаалах гэмт хэргийн талаархи ойлголт мэдлэгийг тогтмол сайжруулах үйл явц удаашралтай, бодит байдалд хохирогчдод үзүүлэх хамгаалалт, дэмжлэг хангалтгүй байна. Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт сайн биш, хуулийн байгууллагаас шийдвэрлэж байгаа хэргийн тоо цөөн байгаа нь судалгааны явцад ажиглагдсан юм.

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2014-2016 онд нийт 30 хохирогч бүхий 17 хэргийг илрүүлэн шалгасан байна. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын 90 гаран хувь нь эмэгтэйчүүд, 46% нь насанд хүрээгүй хүүхэд байна.¹

Харин хохирогчид үйлчилгээ үзүүлдэг Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-ын мэдээллээр тус байгууллага адил цаг хугацаанд буюу 2014-2016 онд хүн худалдаалах гэмт хэргийн 129 хохирогчид үйлчилгээ үзүүлжээ.

Зураглал: Хүйсийн тэгш эрхийн төвийн мэдээлэл.

Тэдний дийлэнх хувийг охид, эмэгтэйчүүд, хөдөлмөрийн насны эрчүүд, цөөнгүй хувийг бага болон өсвөр насны хүүхдүүд эзэлж байна.



ХХГХ-ийн хохирогчдын дийлэнхи нь бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалагддаг ажээ.

Хохирогчдын дунд хийсэн судалгаагаар бэлгийн мөлжлөгт өртөж буй хохирогчийн олонхи нь нь гэр бүл дэх хүчирхийлэл, зөрчилдөөний улмаас орон гэрээсээ дайжсан охид эмэгтэйчүүд байгаа юм.

Мөн олон жил тэнэмэл байдлаар айл, халамжийн төв дамжин амьдардаг, хөдөө орон нутгаас нийслэлд шилжин суурьшсан, ядуу өрхийн сургууль завсардсан, гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг, зах дээр хөдөлмөр эрхэлдэг, эцэг эх нь салсан, хойд эцэгтэй гэр бүлийн охид бэлгийн мөлжлөгт илүү ихээр өртөж байна.

Хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хүмүүсийн олонхи нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичиг баримтгүй болон хөдөө орон нутгаас шилжин суурьшигч, мэргэжил боловсролгүй, орлого багатай, амьжиргааны баталгаажих түвшин доогуур иргэн байна.

Өнгөрсөн хугацаанд бэлгийн мөлжлөгийн хэлбэрийг илрүүлэх, шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон ТББ-уудаас нэлээд анхаарал

¹ЭЦГ-ын 2017.02.01-ний 13/720 тоотын хавсралт

хандуулсан нь тодорхой үр дүнд хүрсэн хэдий ч хүн худалдаалах гэмт хэргийн олон хэлбэр шинжүүд төдийлэн сайн илрэхгүй байна.

Тухайлбал, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль батлагдсанаас хойш буюу 2012-2016 оны байдлаар цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн энэ төрлийн хэргүүдийг бүхэлдээ бэлгийн мөлжлөгийн хэрэг эзэлж байна.

Хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор үйлдэгдсэн гэмт хэргийн илрүүлэлт хангалтгүй, иргэдийн дунд ойлголт мэдлэг муугаас хохирогч болох хүмүүс хуулийн байгууллагад мэдээлэхгүй байх, хөдөлмөрийн дийлэнх салбарт жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, хувийн аж ахуйн нэгж, компани, хувиараа аж ахуй эрхлэгчид, малчид бусдын хөдөлмөрийг хууль бусаар ашиглах явдал түгээмэл байсаар байна.

Тохиолдол 1. Хүн худалдаалахтай тэмцэх тухай бие даасан хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2012 онд батлан гаргасан. Үүнтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл буюу “Хүн худалдаалах” гэмт хэргийн талаархи зүйл ангид холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

Эрүүгийн хуулийн 113-р зүйлийн 113.2.3-т заасан насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөрийг мөлжих зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн нэг хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж прокурор яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн байна.

Харин шүүхийн шатанд эрүүгийн хуулийн 113-р зүйлийн 113.2.3-т заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн байхгүй байна гэж үзээд эрүүгийн хуулийн 121 –р зүйл анги буюу насанд хүрээгүй хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэх гэсэн зүйл ангиар өөрчлөн зүйлчилж гэм буруутай этгээдүүдэд ял шийтгэл оногдуулжээ.

Насанд хүрээгүй хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлсэн гэм буруутайд тооцогдсон этгээд хохирогчийн хууль ёсны төлөөлөгчтэй сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тохиролцон тогтоож, хохирогчид нөхөн төлсөн нэг л тохиолдол байна².

Одоогийн байдлаар хүний цус эд эрхтэнг авч ашиглах зорилгоор үйлдэгдсэн гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй байна.

Илрүүлэн шалгасан хэргүүдээс дүгнэхэд бэлгийн мөлжлөгийн зорилгоор Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Зүүн Өмнөд Ази руу чиглэсэн урсгал хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор Европ Азийг чиглэсэн урсгал тогтох хандлагатай байна.

9.ЭРХ ЗҮЙН ОРЧИН

² Эрүүгийн хэргийн анхан шатны 1-р шүүхийн 2014.02.25-ны 274 тоот шийтгэх тогтоол

Олон улсын эрх зүйн баримт бичгүүд:

- **НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох Палермогийн Протокол 2008 он.**

Монгол Улс нь 2008 оны 5 дугаар сарын 16-ны өдөр НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, тус Конвенцийн нэмэлт болох Палермогийн протоколд нэгдэн орсон.

Палермогийн Протоколын 3 дугаар зүйлийн а хэсэгт хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлохдоо: “Бусдыг мөлжих зорилгоор хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл өөр этгээдийг хяналтандаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийх, ашиг олгон хахуульдах замаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах,нуух буюу хүлээн авах”-ыг ойлгоно гэжээ.

Дээрхи тодорхойлолтонд дурьдсан аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч өөрийг нь мөлжих гэж байгааг мэдээд зөвшөөрөл өгсөн байсан ч хэрэгсэхгүй байхаар энэхүү протоколд тодорхойлсон байна..

Харин дээр дурьдсан аргуудыг хэрэглээгүй байсан ч мөлжих зорилгоор хүүхдийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг “хүн худалдаалах” гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.

Хүүхэд гэж 18 нас хүрээгүй хүн бүрийг хэлнэ.

Мөлжих гэдэгт:

- Бусдын биеийг нь үнэлүүлэх
- Бэлгийн харилцаанд оруулан мөлжих
- Албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх
- Боолчлол буюу боолчлолтой төсөөтэй зан заншил
- Эрх чөлөөгүй байлгах
- Эд, эрхтэнийг нь авах зэргийг ойлгоно

Үндэстэн дамнасан шинж чанартай буюу зохион байгуулалттай гэмт бүлэглэл холбогдсон тохиолдолд урьдчилан сэргийлэх, мөрдөн байцаах болон мөрдөн мөшгих ажиллагаа явуулах, хохирогчийг хамгаалахтай холбогдуулан оролцогч улсууд энэхүү протоколыг хэрэглэнэ хэмээн заасан.

Протоколын 2-р хэсэгт ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах, туслах асуудлыг онцлон авч үзсэн. Оролцогч улс бүр хохирогчдын хувийн амьдралыг, бие хүний хувьд ч шүүн таслах ажиллагааг нууц байлгах арга замаар дотоодын хууль тогтоомжоор байж болох арга хэмжээнд хамгаалах ёстой гэж заасан.

Энэ дагуу Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолтыг Палермогийн протоколд нийцүүлэх ажил амжилттай хийгдэж, Хүн худалдаалахтай тэмцэх тухай бие даасан хууль батлагдсан нь чухал ахиц болсон.

- **Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенц 1990 он.**

Монгол Улс нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцид 1990 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр гарын үсэг зурж, 1990 оны 7 дугаар сард соёрхон баталсан байна.

Монгол Улс нь тус конвенцийн гишүүн улсын хувьд хүүхдийг эдийн засгийн мөлжлөгөөс хамгаалуулах болон түүний эрүүл мэндэд хохирол учруулах буюу боловсрол олоход нь саад болох, эсвэл түүний эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, ёс суртахууны болон нийгмийн хөгжилд нь хор уршиг учруулж болзошгүй ямарваа нэгэн ажил эрхлэхээс сэргийлүүлэх үүрэгтэй.

Хүүхэд худалдах, биеийг нь үнэлэх болон хүүхдийг садар самуунд ашиглах тухай Хүүхдийн эрхийн конвенцид оруулсан нэмэлт протоколын гишүүн орны хувьд арилжааны бэлгийн мөлжлөгт өртөх магадлал ихтэй хүүхдийг хамгаалахад онцгой анхаарал хандуулж, хохирогч-аврагдагсдад зохих ёсны бүх тусламж үзүүлэх, үүний дотор тэднийг нийгэмд бүрэн татан оруулах болон бие махбодийн хийгээд сэтгэлзүйн хувьд бүрэн нөхөн сэргээх үүрэгтэй.

- **ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 182-р конвенц 2001 он.**

Монгол Улс нь Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 182-р конвенцийн гишүүн орны хувьд хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаа, садар самуун сурталчилгаа болон садар самууны үзүүлбэрт ашиглах, элсүүлэн авах, зуучлах эсвэл үүнийг санал болгох, мөн чанар, эсвэл хөдөлмөрийн нөхцлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэхүйц ажлыг хүүхдээр эрхлүүлэхийг хориглосон заалтуудыг дотоодын хууль тогтоомжинд оруулах, конвенцийг хэрэгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх болон нийгэм эдийн засгийн хөгжил, ядуурлыг арилгах хөтөлбөр, бүх нийтэд боловсрол олгох чиглэлээр дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Энэхүү конвенцид боолчлолын бүх хэлбэрүүд болон хүүхдийг худалдаалах, хил дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглахын тулд

хүүхдийг хүчээр буюу албадан элсүүлэх буюу зуучлах зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаануудад оролцуулахыг хориглосон.

Үүний дагуу Эрүүгийн хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар ХХГХ-ийн хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэгийг хуульчилсан. Гэвч бодит байдалд хохирогч хүүхдийн хамгаалалт хангалтгүй, хүүхдэд үзүүлэх төрөлжсөн үйлчилгээ байхгүй хэвээр байна.

Харин Монгол Улсын шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт заасан ажлыг хийлгэхээр хүүхдэд хүч хэрэглэсэн этгээдийг торгох, 1 жил хүртэлх хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах 1 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэхээр заасан. Хүүхдээр гуйлга гуйлгах, биеийг нь үнэлүүлэх, хүүхдийг садар самуунд хүчээр оролцуулах, садар самуун агуулгатай зүйлийг бэлтгэх, худалдах, түгээх болон хадгалахад ашигласан тохиолдолд мөн 16 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

Шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэсэн 16-р зүйлийн 16.10-д хүүхдээр аюултай ажил, эрүүл мэнд, бие бялдар, оюун санаанд нь хохирол учруулахуйц хориглосон ажил, үйлчилгээ зориуд эрхлүүлэхийг хориглосон байна.

- **Албадан хөдөлмөр эрхлэлтийн тухай ОУХБ-ын 29, 105 дугаар конвенц 2005 он**

Монгол Улс ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29-р конвенцийг 2005 онд соёрхон баталсан. Харин 2005 онд Албадан хөдөлмөр эрхлэлтийг устгах тухай 105-р конвенцийг соёрхон баталсан боловч, Албадан Хөдөлмөрийн тухай 29, 105 дугаар конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор 2014 онд ОУХБ-с баталсан Албадан Хөдөлмөрийн Протоколыг (цаашид 29-р Протокол гэж нэрлэх) протоколыг Монгол Улс хараахан соёрхон батлаагүй байна.

Бүс нутгийн эрх зүйн баримт бичгүүд :

Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг тэмцэх үйл ажиллагаанд дэлхийн улс орнууд бүсийн хэмжээндээ болон улс орнуудын хооронд ихэвчлэн санамж бичиг байгуулах, харилцан гэрээ байгуулах замаар ажиллаж байна.

Ялангуяа Азийн бүсийн улс орнуудын хувьд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нарын тоо бусад тивүүдээс өндөр байдаг бөгөөд үүнтэй уялдан Азийн тэр дундаа Зүүн Азийн улс орнуудын засгийн газрууд энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд ихээхэн хүчин чармайлт гарган ажилласаар байна.

Олон талт болон хоёр талын хамтын гэрээ:

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар Монгол Улсын Засгийн газар нь хүн худалдаалах чиглэлээр гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах арга хэмжээнд анхаарал хандуулах үүрэгтэй ч өнөөг хүртэл бүс нутгийн хамтын ажиллагаа, гэрээ хэлэлцээрт төдийлөн идэвхитэй оролцогч байж чадахгүй хэвээр байна.

2010 онд ХХГХ-тэй тэмцэх асуудлаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Макаогийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн Засгийн Газар Хоорондын Хэлэлцээр байгуулсан. Гэвч хууль хэрэгжсэнээс хойш нэмж өөр бусад улс орнуудтай хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулаагүй байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Макаогийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн Засгийн Газар Хоорондын гэрээний хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх уулзалтыг 2 жил тутамд зохион байгуулахаар гэрээнд тусгасан байна. Гэвч хэрэгжилтийг дүгнэх уулзалт тогтсон хугацаанд хийгддэггүй байна.

ХЗДХЯ-наас ирүүлсэн мэдээллээр хэлэлцээрийн хэрэгжилтийг дүгнэх уулзалтыг 2014 онд 1 удаа хийсэн байна.³

Энэхүү хамтын ажиллагааны гэрээ нь хэрэг зөрчлийн нөхцөл байдлыг үнэлээд гэмт хэргийн гаралт, тогтвортой гарч буй хэргийн тоо зэргийг үндэслэн сунгах эсэх асуудлыг 2 талын ЗГ-ын төлөөлөл шийдвэрлэх боловч 2016 онд гэрээ дүгнэх уулзалт хийгдээгүй ажээ.

Монгол Улс нь 2016 оны байдлаар нийт 20 улстай 28 төрлийн эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг байгуулсан байна. Тэдгээрээс иргэний хэрэг 17 улстай, эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг 17 улстай, гэмт этгээдийг шилжүүлэх тухай гэрээг 17 улстай, ялтан шилжүүлэх тухай гэрээг 9 улстай тус тус байгуулжээ.

Үүнд(Болгар, Вьетнам, Герман, Казахстан, Киргиз, Куба, ОХУ, Польш, Румын, Словак, БНАСАУ, БНСУ, Турк, Украин, Унгар, Франц, Хятад, Чех, Энэтхэг, Югослав), 4 улстай гэмт этгээдийг шилжүүлэх гэрээ (Казахстан, БНСУ, Хятад, Энэтхэг), 15 улстай консулын конвенц (АНУ, Афганистан, Болгар, Вьетнам, Их Британи, Куба,

³ХЗДХЯ-ны 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 1-4/769 тоот албан бичиг.

Лаос, ОХУ, Румын, Словак, БНАСАУ, Унгар, Хятад, Чех, Югослав) байгуулсан болно.

Гэвч Монгол Улсын иргэд ихээр зорчих болсон, мөн хил дамжуулан худалдаалах гэмт хэрэг ихээр гардаг Малайз, Сингапур, Хонконг, Тайланд, Филиппин, Макао зэрэг улс орнуудтай өнөөг хүртэл эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээгүй хэвээр байна.

Үндэсний эрх зүйн бичиг баримтууд болон ХХТтХуулийг шүүхийн практикт хэрэглэж байгаад хийсэн дүн шинжилгээ

Монгол Улсын төр нь 1992 оны Үндсэн хуулийн 19-р зүйлийн 1-д заахдаа "...хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах." үүргийнхээ дагуу хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль зүйн баталгааг бүрдүүлэх чиглэлд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Анх 1998 онд Монгол Улс Эрүүгийн хуулийн 111-1-д "хил дамжуулан биеийг нь үнэлүүлсэн бол" 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр зааж байсан бол 2002 оны эрүүгийн хуулийн 113-р зүйл ангиар өргөжүүлэн хуульчилж хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн мөлжлөгөөс гаднах бусад хэлбэрийг багтаан бие даасан гэмт хэрэг болгон, хориглон хуульчилсан билээ.

Монгол улс нь НҮБ-ын үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол /Палермо Протокол/ -д 2008 оны 5 сарын 16 нд нэгдэн орсон гишүүн улсын хувьд Протоколын зүйл заалтад нийцүүлэхийн тулд Эрүүгийн хуульд зохих нэмэлт өөрчлөлт оруулсан болно.

Улмаар 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай бие даасан хууль батлагдсан нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд томоохон ахиц болсон юм.

Энэхүү хууль нь хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг нь тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалах зорилготой бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд төрийн байгууллагын үүрэг, хариуцлага, хохирогчид үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хохирогчийг нөхөн сэргээх ажиллагаа, төрийн бус байгууллага болон хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн оролцоог төрөлжүүлэн зохицуулсан.

Ийнхүү бие даасан хуулиар хүн худалдаалах гэмт хэргийн онцлог шинжээс хамаарч урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалалтаар хангах, үйлчилгээ

дэмжлэгт хамруулах асуудлыг зохицуулсан нь ач холбогдолтой болсон төдийгүй “Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон **эсэхээс үл шалтгаалан** хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүн”-ийг “хохирогч” гэж заасан нь дэвшилттэй болжээ. Энэхүү заалтын дагуу ТББ-ууд, ялангуяа хохирогч хамгааллын чиглэлээр ажилладаг байгууллагууд хүний наймаанд өртсөн хохирогчдод анхан шатны үнэлгээ хийн, хохирогчоор тогтоон шаардлагатай үйлчилгээг үзүүлж байна. Жишээлбэл, Шведийн Талита Ази байгууллагын Монгол дахь салбар хохирогчдод удаан хугацааны хамгаалалт, туслалцааг тасралтгүй үзүүлж байна.

Тус хуульд зааснаар хохирогч нь аюулгүй байдлын болон эрүүл мэнд, сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ, хууль зүйн туслалцаа, ажлын байраар хангуулах, мэргэжлийн сургалтанд хамрагдах үйлчилгээнд үнэ төлбөргүй хамрагдахаар байна.

Мөн насанд хүрээгүй хохирогч буюу хохирогч хүүхдийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн эсрэг үйлдэгдэх ХХГХ-ийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр тусгай арга хэмжээ авах талаар зохицуулалт тусгажээ.

Өнөөдөр манай улсад тус хуулийн хэрэгжилтийг дэмжих, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага тооцох, хохирогчийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр НҮБ-ын олон талт гэрээнд нэгдэн орсноос гадна дараахь хууль, эрх зүйн цогц зохицуулалтын хүрээнд шийдвэрлэж байна.

Үүнд:

- Эрүүгийн хууль;
- Эрүүгийн байцаан шийтгэх хууль;
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Зар сурталчилгааны тухай хууль;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
- Эрүүл мэндийн тухай хууль;
- Гадаадаас ажиллах хүч авах, гадаадад ажиллах хүч гаргах тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль



Эрүүгийн хууль

1998 онд Монгол Улсын Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийг хориглон хуульчилсан хэдий ч энэ нь зөвхөн хил дамжуулан биеийг нь үнэлүүлэхээр хязгаарлагдаж байсан юм.

Харин 2002 онд энэ төрлийн гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл “Хүн худалдах, худалдан авах” гэсэн хуулийн зохицуулалтаар өргөжүүлсэн.

Гэвч тухайн үеийн энэ зохицуулалт нь хүн худалдах, худалдан авах гэсэн нэр томъёог хэрэглэсэн учраас энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхэд худалдан авсан хүнийг тогтоох шаардлагатай гэдэг үндэслэлээр шүүхээр гэм буруутай этгээдэд хариуцлага тооцож чадахгүйд хүрч байсан. Мөн уг зүйл ангид хүн худалдаалах ЗОРИЛГЫГ мөлжихөөс гадна “ашиг олох” гэж давхар тодорхойлсноос гэмт хэрэгтэн хэдий хэмжээний ашиг олсон нь нотлогдохгүй байна гэсэн үндэслэлээр нэлээдгүй хэрэг хэрэгсэхгүй болж байсан практик бий.⁴

Иймд дээрхи 113-р зүйлийг 2008 оны 2 дугаар сарын 1 ний өдрийн хуулиар өөрчлөн найруулж хүн худалдаалах гэсэн нэр томъёог ашиглах болж худалдан авсан этгээдийг тогтоох шаардлагагүй буюу хүнийг худалдаалж ашиг олох зорилгоор элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол хүн худалдаалах гэмт хэргийг үйлдсэн байх хууль зүйн эх үндсийг тавьсан байна.

Гэсэн хэдий ч Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл ангид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх замаар биеийг нь үнэлүүлэх тухай заалт байсан учраас хүн худалдаалах гэмт хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэхдээ бас л маргаан дагуулсан хэвээр байсан юм.

Шүүхийн практикт : Эрүүгийн хуулийн 124-р зүйл, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зоион байгуулах гэмт хэргийг үндсэнд нь зөв зүйлчилж байгаа боловч насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэн авч явж, зодож хүчээр биеийг нь үнэлүүлсэн үйлдлийг хүн худалдаалах гэмт хэргээр зүйлчлэхгүй Эрүүгийн хуулийн 124-р зүйл Биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэсэн хөнгөн зүйлээр зүйлчилж ноцтой гэмт хэрэгтнийг ял завшуулж байгаа буруу хандлага байгааг таслан зогсоох шаардлагатай юм. Үүнд биеэ үнэлж байгаа этгээдийн хүсэл зориг, үйлдэлдээ хандах харьцаа зэрэг нь насанд хүрсэн хүний үйлдлээс өөр байгааг төдийлэн сайн анхаарахгүй байгаа байдал хэвээр үргэлжилж байна.

2008, 2012 онуудад эрүүгийн хуулийн 113-р зүйл ангид өөрчлөлт орж , мөн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль батлагдан гарсан.

⁴ХАБСТ, Нийслэлийн шүүхийн хийсэн хамтарсан судалгаа. 2010 он.

Төрийн болон төрийн бус байгууллагуудаас тодорхой давтамжтай сургалт, сурталчилгаа явуулснаар дээрхи гэмт хэргийн шийдвэрлэлт харьцангуй сайжирчээ

Мөрдөн байцаалтын шатанд хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүн байна гэж үзээд эрүүгийн хуулийн 113-р зүйл ангиар зүйлчлэн шүүхэд шилжүүлэхэд ихэвчлэн эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл ангиар зүйлчлэн гэмт хэрэгтнүүдэд ял завшуулах, хохирогчийн эрх ашгийг хамгаалах асуудал орхигдож байсан.

Иймд 2012 оны 1 дүгээр сарын 19 ны өдөр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль батлагдсантай холбогдуулан 8 хуульд нэмэлт өөрчлөлт орсоны нэг нь Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсгийн “хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх замаар” гэснийг бусдыг хэмээн өөрчлөлт орсноор хүн худалдаалах гэмт хэргийг зөв зүйлчлэхэд ач холбогдлоо өгсөн.

Мөн эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлийн 115.1 дэх хэсгийн “ ... гуйланчлал болон биеэ үнэлэхэд” гэснийг “ гуйланчлалд” гэж мөн 123 дугаар зүйлийн 123.3 дахь хэсгийн “ насанд хүрээгүй хүнд хүч хэрэглэх буюу” гэснийг хассан нь ач холбогдолтой болсон байна.

2017 оны 7 дугаар сарын 1 хүртэл үйлчилж байсан Монгол Улсын Эрүүгийн хуулиар(2002 он) “хүн худалдаалах” нь 15 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх онц хүнд гэмт хэрэгт тооцогддог байв.

Хүн худалдаалах гэмт хэрэг гэж хүний биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг авч ашиглах зорилгоор элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан аливаа үйлдэл хамаарна.

Гэмт этгээд энэхүү үйлдлээ хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, түүнчлэн өөр хүнийг эрхшээлдээ байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, ашиг олгон хахуульдах аль ч хэлбэрээр үйлдсэн байж болох бөгөөд хохирогч өөрөө зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

Хүн худалдаалах гэмт хэргийг давтан,хоёр буюу түүнээс олон хүнийг, насанд хүрээгүй хүнийг, хүний эд эрхтэнг авах зорилгоор,сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүйд тооцогдсон хүнийг, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг,хуурамч бичиг баримт ашиглан,хохирогчийн бичиг баримтыг авах, нуух, устгах арга хэрэглэж, улсын хил давуулан, илтэд жирэмсэн хүнийг худалдаалсан, мөн урьдчилан үгсэж тохиролцсон

бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол ял шийтгэлийг хүндрүүлэхээр хуульчилсан.

Хүүхэд буюу арван найман насанд хүрээгүй хүнд дээр дурьдсан аргыг хэрэглээгүй ч хүн худалдаалах гэмт хэргийн зорилгоор элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун дарагдуулсан, дамжуулсан, хүлээн авсан бол хүн худалдаалсанд тооцохоор заасан байна.

Монгол Улс Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Эрүүгийн хуулийн Шинэчилсэн найруулга 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан боловч 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн юм.

Шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн 13.1-р дүгээр зүйлд “Хүн худалдаалах” гэмт хэргийг хориглон заасан бөгөөд 2002 оны Эрүүгийн хуулийн зохих заалттай харьцуулан хүснэгтээр үзүүллээ.

Хуучин эрүүгийн хууль

Шинэчлэн найруулсан эрүүгийн хууль

2002 он

2015 он

	113 дугаар зүйл. Хүн худалдаалах	13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах
1	Хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, түүнчлэн өөр хүнийг эрхшээлдээ байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, ашиг олгон хахуульдах аргаар хүнийг хүн худалдаалах гэмт үйлдэлд элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан дамжуулсан, хүлээн авсан бол эд хөрөнгийг хурааж, гурваас таван жилхүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж , эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
2	2.Энэ хэргийг: <ul style="list-style-type: none"> • давтан • хоёр буюу түүнээс олон хүнийг; • насанд хүрээгүй хүнийг; 	2.Энэ гэмт хэргийг: <ul style="list-style-type: none"> • хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж;

	<ul style="list-style-type: none"> • хүний эд эрхтэнг авах зорилгоор; • сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүйд тооцогдсон хүнийг; • хөгжлийн бэрхшээлтэй хүнийг; • албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг; • хуурамч бичиг баримт ашиглан; • хохирогчийн бичиг баримтыг авах, нуух, устгах арга хэрэглэж; • улсын хил давуулан; • илтэд жирэмсэн хүнийг худалдаалсан бол эд хөрөнгийг хурааж, таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 	<ul style="list-style-type: none"> • хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж; • Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3	<p>Энэ хэргийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, <u>түүнчлэн энэ хэргийн улмаас хүнд хор үршиг учирсан</u> бол эд хөрөнгийг хурааж, арваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>Энэ гэмт хэргийг:</p> <ul style="list-style-type: none"> • байнга тогтвортой; • зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ
	<p>Тайлбар:</p> <p>1.Энэ хуулийн 113.1-д заасан “мөлжих” гэдгийг худалдаалагдсан хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг нь авч ашиглах гэсэн утгаар ойлгоно.</p> <p>2.Энэ хэргийг үйлдэхдээ хохирогчийн эсрэг хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашигласан, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл өөр хүнийг эрхшээлдээ байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлж буюу ашиг олгон хахуульдах аргын аль нэгийг хэрэглэсэн тохиолдолд хохирогч өөрийг нь мөлжихийг</p>	<p>Тайлбар: -Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.</p> <p>-Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.</p>

<p>зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>3.Энэ хуулийн 113.1-д заасан аргыг хэрэглээгүй байсан ч арван найман насанд хүрээгүй хүнийг хүн худалдаалах гэмт хэргийн зорилгоор элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун дарагдуулсан, дамжуулсан, хүлээн авсан бол хүн худалдаалсан гэж үзнэ.</p>	
---	--

Дээрх харьцуулалтаас үзэхэд ХХГХ-ийг үндсэн шинжүүдийг тусгай тайлбар хэсэгт заасан байсныг өөрчилж, гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд оруулан нэмж тусгаснаас гадна ялын бодлогыг чангатган хорих ялын дээд хэмжээ 5 жил хүртэл байсныг 8 жил хүртэл болгон, мөн байнга тогтвортой, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол бүх насаар хорих ял шийтгэхээр нэмэгдүүлсэн нь дэвшилттэй юм.

Мөн хүн худалдаалах гэмт хэрэг нь итгэл эвдэх аргаар үйлдэгдэж болохыг зааж, ямарч нөхцөлд хүн худалдаалах гэмт хэрэгт хохирсон хохирогчийн зөвшөөрөл нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хууль хяналтын байгууллагаас эрүүгийн хуулийн хүн худалдаалах гэмт хэргийг зохицуулж буй зүйл ангиар зүйлчилэхэд нөлөөлөхгүй байхаар хуульчилсан нь хохирогчоос ямар нэгэн нотолгоо шаардахгүй байх боломжийг бүрдүүлжээ.

Үүнээс гадна хүн худалдаалах, хүн хулгайлах гэмт хэргийн хохирогч болсон хүн баримт бичиггүйгээр, хуурамч баримт бичгээр Монгол Улсын хил нэвтэрсэн нөхцөлд энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй байх, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн хүнийг хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр тэнсэж, ялаас чөлөөлөхгүй байх зохицуулалтыг Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 7.1-2 т тусгасан.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 7.5-3-т шүүх нь гэмт этгээдийн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүний хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулах албадлагын арга хэмжээг оногдуулсан ял дээр нэмж хэрэглэхээр зохицуулсан.

Ийнхүү 2002 оны хуулиар эд хөрөнгө хураах ялыг гэмт этгээдэд оногдуулах боловч хураасан хөрөнгийг зөвхөн төрийн өмчлөлд шилжүүлэхээр заасныг өөрчилж гэмт этгээдийн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхэд зарцуулахаар тусгасан нь нь хохирогчид ээлтэй чухал зохицуулалт болсон.

Эрүүгийн хууль/Шинэчилсэн найруулга/-2015 он /

7.5 дугаар зүйл. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ

1.Бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө,

Мөн тус хуулийн 12.3 дугаар зүйлд “Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулах”-ыг “Бэлгийн мөлжлөг”-ийн гэмт хэрэг хэмээн тусгайлан хориглон хуульчилсан байна. Энэ нь 13.1 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэргээс ялгахад бэрхшээлтэй төдийгүй хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг давхардуулан тодорхойлсон нь төөрөгдөл үүсгэх, гэмт этгээд ял завших боломж олгох эрсдэлтэй байна.

Учир нь бэлгийн мөлжлөг болон хүн худалдаалах гэмт хэргийн гол ялгаатай шинж нь хохирогчийн зорчих эрхийг хязгаарлахгүй байхаар тогтоосон нь оновчтой биш. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хувьд зорчих эрх нь шууд хязгаарлагдаагүй, чөлөөтэй байгаа мэт боловч айдас, дарамт болон бусад байдлаас шалтгаалан сэтгэл зүйн хувьд гэмт этгээдээс хараат болох, гэмт хэрэгтнүүдийн эрхшээлд орсон байдаг.

Энэ нөхцөлд гэмт этгээдээс зугтаах боломжгүй, хууль хяналтын байгууллагад хандах, гомдол гаргах, бусдад мэдэгдэх зэргээр өөрийгөө хамгаалах чадваргүй болсон байдаг. Гэтэл үүнийг зорчих эрх нь хязгаарлагдаагүй гэж үзэх нь учир дутагдалтай юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хууль: 2002 он

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг оролцуулах ажиллагааг зохицуулсан тусгай журам байхгүй бөгөөд бусад төрлийн гэмт хэргийн хохирогчийн нэгэн адил эрх, үүргийг эдлэхээр хуульд заасан байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлд “хохилогч” гэдгийг тодорхойлохдоо “гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ” гэсэн боловч “хохилогч хүүхэд” гэж тусгайлан заагаагүй байна. Хохирогч хүүхэд нь эрүүгийн хэрэг шийдвэрлэх үйл ажиллагааны онцгой субъектүүдийн нэг учраас хүүхдийн сэтгэл зүй, хэргийн нөхцөл байдал зэргээс шалтгаалан нарийвчлан зохицуулах нь хүүхдийн цаашдын хөгжилд ач холбогдолтой юм.

ХХГХтТХ-иар “хохилогч” гэж Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг хэлнэ гэж хуульчилсан заалттай зөрчилдөж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хохирогчийн эрхийг заахдаа өмгөөлөгч авах, нотлох баримтыг шалгуулах хүсэлт гаргах, гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, цагаатгах болон шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж заалдах болон хяналтын шатны журмаар гомдол гаргах эрхтэй гэсэн цөөн хэдэн эрхийн хүрээгээр хязгаарлаж, хохирогчийг хамгаалах талаар ямар нэгэн заалт байхгүй байна. Хууль хяналтын байгууллагаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шалгуулж гэм бурууг нь шүүхээр тогтоолгохоор зорьж буй хохирогчийн хувьд ЭБШХ-иар мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд хувийн аюулгүй байдлыг нь хамгаалах тухай заалтыг оруулснаар хохирогчид айх аюулгүй шүүхээр хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл оролцох боломж нь хангагдах юм.

Ялангуяа хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, мөн насанд хүрээгүй, хөгжлийн бэрхшээлтэй, бичиг үсэг мэдэхгүй, төлбөрийн чадваргүй зэрэг эмзэг хохирогчийн хувьд аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, мэдээллээр хангах зэргээр байцаан шийтгэх ажиллагаанд тусгай журмыг хэрэгжүүлэх нь чухал юм.

Иймд УИХ-ийн хэлэлцүүлгийн шатанд байгаа “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуулийн төсөлд энэхүү гэмт хэргийн онцлог, хохирогч, гэрчийн эмзэг байдлыг харгалзсан хохирогчийг хамгаалалт, дэмжлэгээр хангахад чиглэсэн зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль: 2012 он

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогч гэж “Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон **эсэхээс үл шалтгаалан** хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүн”-ийг гэж заасан нь дэвшилттэй боловч 2013 онд батлагдсан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд зааснаар тус хуулийн дагуу хохирогчийн хамгаалалтыг **Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн дагуу тухайн хүнийг хохирогчоор тогтоосон** тогтоолыг цагдаа, прокурор, шүүхээс гаргасан байхыг шаардсан байна.

Өөрөөр хэлбэл Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан биечилсэн хамгаалалт, мэдээллийн нууцлалыг хангуулахаас эхлээд нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангуулах, нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх зэрэг илүү өндөр зэрэглэлийн хамгаалалтыг Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуульд заасан хохирогч авах боломжгүй болж байна.

Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь эрүүгийн хэрэгт хохирогчоор тогтоогдоогүй бол Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийг дагаж батлагдсан Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам, Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам, Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журамд заасан хамгаалалт дэмжлэгийг авах боломжгүй болж байна.

Хохирогчид учирсан амь нас, эд хөрөнгө, бие махбодь, сэтгэл санааны хохирлыг үнэлэх, барагдуулах, нөхөн төлүүлэх, нөхөн сэргээх талаар хууль тогтоомж, төрийн бодлогын баримт бичгүүдэд хангалттай тусгагдсан ч хохирлын тухай ойлголтыг нарийвчлан тодорхойлоогүйгээс **амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлыг үнэлж, нөхөн төлүүлсэн практик байхгүй байна.**

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд

15.1.Хохирогч нь эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй.

15.2.Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө.

15.3.Хохирогчийн сэтгэл санааны хохирлын хэмжээг түүний нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хохирогчид учирсан гэм хорын хэр хэмжээг харгалзан шүүх тогтооно гэж заасан нь дэвшилттэй боловч холбогдох бусад хуультай уялдаагүйгээс хэрэгжих боломжгүй байна.

Тухайлбал: Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд зааснаар хохирогч хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй авах эрхтэй бөгөөд хохирогчид хууль зүйн

туслалцаа үзүүлэх журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд батлахаар Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12.4-т заасан боловч одоог хүртэл батлан мөрдүүлээгүй байна.

Харин гэмт хэрэгтний хувьд 2013 онд батлагдсан “Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай” хуулийн дагуу төлбөрийн чадваргүй нөхцөлд төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах эрхтэй бөгөөд дээрх чиг үүрэг бүхий дагнасан 58 өмгөөлөгч⁵ улсын хэмжээнд ажиллаж байна. Харин төлбөрийн чадваргүй хохирогчдод төрөөс үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах боломж өнөөдрийн байдлаар хуульчлагдаагүй байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг дагаж 9 төрлийн журмыг батлан мөрдүүлэхээр хуульчилсан. Үүнд:

- Эрүүл мэндийн сайд хохирогчид эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, хохирогчийг сэтгэцийн нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах журмыг;
- Хөдөлмөр нийгэм хамгааллын сайд хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжил олгох журмыг;
- Хууль зүй, дотоод хэргийн сайд хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх, Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах, иргэн, байгууллага, албан тушаалтанд урамшуулал олгох журмыг, мөн Улсын ерөнхий прокурортой хамтран хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журмыг;
- Гадаад харилцааны сайд гадаад улсад байгаа хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчирах журмыг;
- Засгийн газар нь хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмыг батлан, хэрэгжилтийг ханган ажиллах үүргийг хүлээсэн.

Өнөөдрийн байдлаар дараахь журмууд батлагдсан байна:

	Хариуцсан байгууллага	Журам	Батлагдсан огноо
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	ХХГХ-ийн хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам	Хөдөлмөрийн сайдын 2013/07/16-ны өдрийн А/142 тоот тушаал
2	Эрүүл мэндийн яам	ХХГХ-ийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх	Эрүүл мэндийн сайдын 2013/12/09-ны өдрийн 462 тоот тушаал

⁵Хууль зүйн туслалцааны төвийн цахим хуудас. www.lac.gov.mn

		журам	
3	Гадаад харилцааны яам	ХХГХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам	Гадаад харилцааны сайдын 2013/11/15-ны өдрийн А/91 дүгээр тушаал

Үүнээс дүгнэхэд хохирогчид үйлчилгээ үзүүлэх хамгийн эхний журам хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс буюу 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрөөс хойш 1 жил 6 сарын дараа батлагдан хэрэгжсэн байна. Энэ хугацаанд хохирогчид хуульд заасан үйлчилгээг зохих журмын дагуу авч чадахгүй байсныг харуулж байна.

Эдгээр журмууд нь 2013 онд батлагдсан боловч 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдсөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмуудтай давхардсан гэдэг үндэслэлээр нийтлэг байдлаар гэмт хэргийн хохирогчид үйлчлэх журамд багтаан зохицуулж байна.

Эрүүл мэнд, Хууль зүйн сайдын 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 356/А/182 дугаар хамтарсан тушаалаар Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журмыг, Хууль зүйн сайдын 2014 оны А/122 дугаар тушаалаар Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам, мөн Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаалаар Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журмыг тус тус баталжээ.

Өөрөөр хэлбэл Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш даруй 2 жил 10 сарын дараа эдгээр хамгаалалт, дэмжлэг үзүүлэх журмуудыг баталсан байна.

Энэ нь зөвхөн цаг хугацааны хувьд тооцсон дүгнэлт бөгөөд журам батлагдсан нь энэ үйлчилгээг хохирогчид бүрэн авч чадаж байгааг илэрхийлэх үзүүлэлт биш юм.

Харин дараахь журмууд батлагдан гараагүй байна. Үүнд:

1. ХЗДХ-ийн Сайдаас батлах

- Хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам
- Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтныг урамшуулах журам

2. ЭМ-ийн Сайдаас батлан гаргах

- ХХГХ-ийн хохирогчид эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх журмууд
- Хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журам.

ХХТТХ-иар ХЗДХЯ, ГХЯ, НХХЯ, БСШУСЯ болон Цагдаагийн байгууллага, Гадаадын иргэн харьяатын газар, Мэргэжлийн хяналтын байгууллага, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, бүх шатны Засаг дарга, иргэдийн хуралд тусгайлан үүрэг хүлээлгэсэн байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль: 2013 он

2013 онд батлагдсан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар хохирогч нь аюулгүй байдлын болон сэтгэл зүйн хамгаалалт авах эрхтэй бөгөөд гэрч, хохирогчийн аюулгүй байдалтай холбогдуулан бусад этгээдэд урьдчилан сануулах, тодорхой үйлдлийг хязгаарлахаас гадна хохирогчийг биечилсэн хамгаалалтаар хангах, мэдээллийн нууцлалыг хангах, нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах, аюулгүй газарт түр байрлуулах, нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх

арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан.

Мөн хамгаалалтад байгаа гэрч, хохирогч нь хууль зүй, сэтгэл зүй, эрүүл мэндийн туслалцаагаар үнэ төлбөргүй хангагдахаар заажээ.

Тус хуулийн хэрэгжилтийг дагнан хариуцах Тахарын албыг 2014 онд байгуулсан.

Тахарын алба нь ажилласан 2 жилийн хугацаанд нийт 144 хүнийг хамгаалалтаар хангасны дотор хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч зөвхөн 1, түүнтэй

Гэрч, хохирогчийг хамгаалах газрын 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн тоот албан бичгийн нэгдүгээр хавсралт

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ГАЗРЫН ХАМГААЛАЛТАД АВАГДСАН ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН ТООН СУДАЛГАА

2016.07.18

№	Үзүүлэлтүүд		2014	2015	2016 эхний 7 сарын байдлаар
1	Хамгаалалтад авагдсан	гэрч	1	7	4
		хохирогч	19	32	23
		хамгаарал бүхий этгээд	10	36	12
		Бүгд	30	75	39
2	Хүн худалдаалах гэмт хэргийн	гэрч	-	-	-
		хохирогч	-	1	-
		хамгаарал бүхий этгээд	-	2	-
		Бүгд	-	3	-
3	Аюулгүй газарт түр байрлуулсан	гэрч	-	1	1
		хохирогч	2	2	2
		хамгаарал бүхий этгээд	3	11	-
		Бүгд	5	14	3

Жич: Дээрх тоон мэдээлэлд шүүгч, улсын яллагч, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан иргэн, тэдгээрийн хамгаарал бүхий этгээдийн тоо ороогүй болно.

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ГАЗАР

хамаарал бүхий бусад этгээд 2 байсан байна.⁶

Гэтэл энэ цаг хугацаанд хүн худалдаалах гэмт хэргийн 154 хохирогч Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-аас туслалцаа, хамгаалалт авахаар хандсан байна.⁷

Харин УИХ-ын 2016 оны 12-р тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн дагуу Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудыг байгуулж, орон тооны хязгаарыг баталсан.

Энэ тогтоолын хүрээнд Тахарын Ерөнхий Газрыг татан буулгахаар 2016 оны 8 сард шийдвэрлэсэн.

Тахарын Ерөнхий Газрын чиг үүргийг холбогдох агентлагуудад шилжүүлсэн ба гэрч, хохирогчийг хамгаалах үүрэг нь Цагдаагийн Ерөнхий Газрын гэрч хохирогчийг хамгаалах хэлтэст 2016 оны 8 сараас эхлэн шилжжээ.

Нийслэлд ажиллаж байсан Тахарын албаны бүтэц бүхэлдээ ЦЕГ-ын харьяа ирж ажиллаж байна. Харин орон нутагт дагнасан бүтэц байхгүй байгаа юм байна.

Тахарын алба ажиллаж байх үед хохирогчид болон өмгөөлөгчдийн хүсэлтээр хамгаалалт шаардсан гэрч, хохирогчдыг хамгаалах асуудал хэрэгждэг байсан бол энэхүү алба татан буугдснаас хойш мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн гаргасан шийдвэрээр гэрч, хохирогчдыг хамгаалан ажиллаж байна.

2016 онд гэрч, хохирогчид болоод тэдний хамаарал бүхий 44 хүнийг, 2017 онд 18 хүнийг хамгаалалтанд авч ажилласан байна. Гэвч эдгээр хамгаалалтанд орсон гэрч хохирогчдын дунд хүн худалдаалах гэмт хэргийн гэрч хохирогчид байхгүй байгаа талаархи мэдээллийг ЦЕГ-ын гэрч хохирогчийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн өгсөн ю

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль: 1997 он

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д зааснаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ” хэмээн тодорхойлсон байна.

⁶ Гэрч хохирогчийг хамгаалах газраас гаргасан тоон судалгаа 2016 он..

⁷ Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-ын бүртгэлийн статистикийн мэдээлэл. 2016 он.

Үүнээс хамаарч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг зөвхөн дараахь зардалд зарцуулахаар зохицуулжээ.

Үүнд:

- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллагуудаас иргэд, байгууллагын дунд зохиож байгаа сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх;
- эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлж яваад хохирсон иргэний тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх;
- цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэхийг заасан.

Харин Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг ГХУСАЗЗ-ийн дэргэд ажиллах Дэд зөвлөл хариуцахаар, мөн хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлэхээр заажээ.

Хөдөлмөрийн хууль: 1999 он

Хөдөлмөрийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж заасан боловч албадан хөдөлмөр гэдгийг “хөдөлмөрийн сахилгыг сахиулах, ажил хаялтад оролцсоныг болон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зорилгоор, эсхүл ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн зэргийг үл харгалзан ажилтнаас гүйцэтгэхийг шаардсан ажил, үүргийг” хэлнэ гэж тайлбарласан байна.

Гэтэл үүнд илүү цаг, баяр ёслолын өдрүүдэд ажиллах зохицуулалтыг зөрчин ажиллуулах (хөлс бодолт, хязгаарлалт, хориглолтыг зөрчих), цалин хөлсгүй ажиллуулах, хөдөлмөрийн үр дүн болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлс олгох, хэд хэдэн ажил гүйцэтгүүлээд нэг ажлын хөлс олгох зэргийг хамруулаагүй нь учир дутагдалтай байна.

Мөн Захиргааны хариуцлагын тухай хуульд гэмт хэргийн шинжгүйгээр бусдын хөдөлмөрийг мөлжлсөн этгээдэд ногдуулах хариуцлага, энэ төрлийн зөрчил байхгүй, Эрүүгийн хуульд иргэний хөдөлмөрийг мөлжиж завших гэмт хэргийн тухай заалт, хэнд гомдол гаргах, яаж шийдвэрлэх нь тодорхойгүй хэвээр байна.

Үүнээс шалтгаалан хөдөлмөрийн мөлжлөгийн талаар нийгэмд нэгдсэн ойлголт тогтоогүй, хөдөлмөрөө мөлжүүлж байгаагаа, бусдын хөдөлмөрийг мөлжиж байгаагаа ч хэн аль нь мэдэхгүй байх байдлыг үүсгэж байна.

Нийгмийн халамжийн тухай хууль: 2012 он

Тус хуульд зааснаар олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээг буюу амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, сэргээн засах үйлчилгээнд хамруулах, түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээг хохирогчид төрөөс үнэ төлбөргүй үзүүлэх талаар Нийгмийн халамжийн тухай хуулийн 18-р зүйлд заажээ.

Эрүүл мэндийн тухай хууль: 2011 он

Тус хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т зааснаар эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний төлбөрийг тухайн иргэнээс гаргуулахаар байна.

Энэ нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хүндээр тусдаг бөгөөд эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээнээс бусад үйлчилгээг авахад хүндрэл учирдаг. Учир нь ХХГХ-ийн хохирогчдын ихэнх нь нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байдагтай холбоотой.

Иймд Тус хуульд 2012 онд нэмэлт өөрчлөлт орууснаар бие махбодийн ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэцийн сэргээн засах тусламж, үйлчилгээний зардлыг төр хариуцахаар заасан нь дэвшилттэй юм.

Гэвч энэхүү зохицуулалт бодит байдалд хэрэгжихгүй, зөвхөн цагдаагийн байгууллагад бүртгэгдэн эрүүгийн хэрэг үүсгэсэн хэргийн хохирогчид хамаарч байгаа нь улс орны эдийн засгийн байдалтай холбоотой байж болох юм.

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль 2006 он

2006 онд батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд 2010 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тусгай сангаас тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөрийг нэг удаа олгохоор заасан.

хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болж амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг нөхөн олгохоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн **21³ дугаар зүйлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан гэсэн хэсэгт** эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хохирогчид олгохоор **хуульчилсан** байна.

Гэхдээ тухайн асуудал шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн тохиолдолд буюу шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дээрх хохиролд нөхөн төлбөр олгохоор заажээ.

Энэ нь бодит байдалд хохирогчдод хүндрэл учруулж байна. Тухайлбал, энэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэсэн байдлаас үзэхэд мөрдөн байцаалтын ажиллагаа дунджаар 2-3 жил үргэлжилдэг тул хохирогчид энэ хугацаанд нөхөн төлбөр авах боломжгүй байдаг байна. Учир нь тухайн гэмт хэрэгтний гэм буруугийн асуудал шүүхээр хараахан шийдэгдээгүй байдагтай холбоотой.

Энэхүү хуулийн дагуу 2011 онд зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмыг Засгийн газрын 132 дугаар тогтоолоор баталсан байна.

Тус журамд зааснаар нөхөн төлбөр авах этгээд нь шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 1 жилийн дотор өргөдөл гаргаж болох боловч өргөдлийг нийт ажлын 32 өдөр буюу 2 сар орчим хугацаанд шийдвэрлэхээр байна.

Зар сурталчилгааны тухай хууль: 2002 он

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.3-т “гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах тухай зар сурталчилгаа, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд хүргэхүйц бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, холбоо, цахим сүлжээ ашигласан ил буюу далд зар сурталчилгаа” тараахыг хориглосон.

Мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэргийн шинжтэй зар сурталчилгааг хориглосон, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь гэмт хэргийн шинжтэй, илт хууль бус нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгааны талаар цагдаагийн байгууллагад мэдээлэх үүргийг, мөн Донорын тухай хуулиар донорын эд, эрхтэнг худалдах, худалдан борлуулахаар сурталчлахыг хориглон хуульчилсан боловч Зар сурталчилгааны тухай хуульд энэ талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Түүнчлэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй

мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр яаралтай нийтэлж нэвтрүүлнэ гэж заасан боловч энэ нь зөвхөн төрийн байгууллагаас мэдээлэх, мөн тус мэдээлэл нь яаралтай байх гэсэн үндэслэлээр хязгаарлагдсан нь учир дутагдалтай байна.

Учир нь нийгэмд сөрөг нөлөө ихтэй энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээллийг ТББ-ын зүгээс нийгэмд хандан хийхэд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүй нийтлэх, нэвтрүүлэх боломжгүй байгаа нь ашгийн төлөө өөрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчилах бизнесийн бусад байгууллагын адил зардал төлөхөд хүргэж байна.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль 2001 он.

.Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах талаар хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүн амын хөдөлмөр эрхлэлт, хөрөнгө оруулалтын бүтцийн бодлоготой уялдуулан ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах асуудлаар бодлого, чиглэл тодорхойлох, хэрэгжилтийг хангуулах тухай энэхүү хуулийн 4-р зүйлд заасан байна.

Мөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, хөдөлмөр эрхлүүлэх талаар зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, Монгол Улсад гадаадын иргэд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, татгалзах, хугацааг нь сунгах болон хүчингүй болгох тухай хуульчилжээ.

Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч болон гадаадаас Монгол Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчийн нийгмийн хамгааллын талаар гэрээнд заасан үүргийн биелэлтэд хяналт тавьж, тэдгээрийг хэрэгжүүлэх явцад илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авахаас гадна эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын нийт ажиллагчдын тоо, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулан нийт ажиллагчдын тоонд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг жил бүр тогтоож, Засгийн газраар батлуулах үүрэгтэй.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах асуудлаар төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, гадаадын холбогдох төрийн захиргааны болон төрийн бус байгууллагатай гэрээ байгуулах талаар заажээ.

Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль 1998 он

1998 онд батлагдсан тус хуулиар биеэ үнэлэхийг хориглон зөрчилд тооцсон бөгөөд зөрчсөн бол биеэ үнэлж олсон орлогыг нь хурааж, 14-30 хоногийн

хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулахаар, тус зөрчлийг нэг жилийн дотор давтан гаргасан бол Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Харин биеэ үнэлэлтийг худалдан авсан этгээдэд ямар нэгэн ял, шийтгэл хүлээх хуулийн зохицуулалт байхгүй байна.

Харин 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхлэх Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйлд “Биеэ байнга үнэлж явалдсан, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон бол” зөрчилд тооцон торгох шийтгэл оногдуулахаар заасан бол Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар “хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол” гэмт хэрэгт тооцохоор зааглан хуульчилсан байна. Энэ нь биеэ үнэлэлтийг худалдан авагч этгээдэд зохих хариуцлагыг хүлээлгэхээс гадна сөрөг үр дагаврыг харгалзан биеэ үнэлэлтийг зөрчил, гэмт хэрэгт зааглан хуульчилсан нь дэвшилттэй болжээ.

Гэвч 2002 оны Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлд заасан “Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулсан, биеэ үнэлэхийг зохион байгуулсан” үйлдлийг гэмт хэрэгт тооцож байсныг Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар орхигдуулсан байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 3.3 дугаар зүйлд гэмт хэргийн зохион байгуулагчийг тухайн гэмт хэргийг хамтран үйлдсэн гүйцэтгэгчид тооцон ял шийтгэхээр заасан байна.

Харин Зөрчлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлд зөвхөн зөрчил хамтран үйлдсэн этгээдэд шийтгэл хүлээлгэхээр заасан байна. Мөн хуулийн 6.18.4 дугаар зүйлд **Бусдын биеийг үнэлж бэлгийн харьцаанд орох талаар хуульчилсан. Үүнд:** Биеэ байнга үнэлж явалдсан, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон бол хууль бусаар олсон орлогыг хурааж, тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэжээ. 6.18.7 дугаар зүйлд .Өөрийн эзэмшлийн байр, газарт биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд зуучилсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж хуульчилсан.

Үүнээс дүгнэхэд биеэ үнэлэх зөрчлийг өөрийн байр, эзэмшлийн газаргүй этгээд зохион байгуулсан, санхүүжүүлсэн, унаагаар хангасан, бусад зүйлээр үйлчилсэн нь гэмт хэрэг, зөрчлийн аль, алинд нь тооцогдохгүй бөгөөд биеэ үнэлэлтийг зохион байгуулагч, зуучлагч этгээдийн хууль бусаар олсон орлогыг хураах зохицуулалт байхгүй байгаа нь хуулийн хариуцлагын гадна үлдэж байна. Иймд энэхүү зохицуулалт нь 2002 оны Эрүүгийн хуулийг дордуулсан байна.

Шүүхийн практикт ХХГХ-ийг шийдвэрлэж буй байдал:

Хүйсийн тэгш эрхийн төвөөс судалгаа хийсэн 6 эрүүгийн хэргээс үзэхэд хохирогчид нийт 190,056,822 төгрөгийн хохирлыг нэхэмжилсэн. Шүүхээс зөвхөн эрүүл мэнд, унаа, зайлшгүй тохиолдолд хоол, буудал⁸ зэргийг хохиролд тооцон нотлох баримтанд үндэслэн нэхэмжлэлийн 6% буюу 11,530,772 төгрөгийн нэхэмжлэлийг хангаж өгсөн байна.

Өөрөөр хэлбэл хохирогчийн эдийн бус хохирол, тэр дундаа сэтгэл санааны хохирлыг барагдуулах боломж хууль хоорондын зөрчилдөөний улмаас хязгаарлагдсан байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 391 дүгээр зүйлд “Эдийн бус хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө”, “Эдийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно” гэж заасан боловч Иргэний хуульд “... эдийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан тодорхойлох” журмыг нарийвчлан заагаагүй, эрх зүйн дутуу зохицуулалт хэрэглэгдэж байна.

Энэ нь хохирлын хэмжээг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасанчлан тогтоох боломжгүй болгож байна. 2002 оны Иргэний хуулийн⁹ 230, 511 дүгээр зүйлд “Эдийн бус гэм хорыг арилгах” тухай заасан байх бөгөөд эдгээр зүйлд эдийн бус хохирлыг шаардах эрх, эдийн бус хохирлыг нөхөн төлөх хэлбэр, гэм хорыг арилгах болон гэм хорын хэмжээг тогтооход харгалзах зүйлийг тусгасан боловч “эдийн бус гэм хор”-ыг зөвхөн “бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирол”-оор хязгаарлан тодорхойлсон байна.

Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл зүйн хохирлыг арилгахтай холбоотой Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зохицуулалтыг хэрхэн нэг мөр ойлгож, шүүхийн практикт зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор УДШ-ээс 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 15 тогтоолоор дараахь байдлаар тайлбарлажээ.

Үүнд:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 115 дугаар зүйлийн 115.1-д заасан “эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол” гэдэгт Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д зааснаар бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд ... учруулсан гэм хорыг ойлгоно.

Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь нас, бие

⁸Нэг хэрэгт орон нутгаас ирээд хамаатан садангүйн улмаасУБ хотод зочид буудалд байрласан хохирогч, түүний асранхамгаалагчидунаа, буудал, хоолнымөнгийгбаримтандтулгуурланолгохооршийдвэрлэсэнбайсан.

⁹ 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан.

эрхтний өвчин, зовиур шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлэх боломжгүй.

Улсын дээд шүүхийн тайлбарын дээрх хэсэгт дүн шинжилгээ хийхэд Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар **хохирогчид олгосон эдийн бус хохирол нэхэмжлэх эрхийг зөвхөн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирлоор хязгаарлажээ.**

Өөрөөр хэлбэл, дээрх тайлбарын заалтаар хохирогч *гэмт хэргийн улмаас сэтгэл зүйд учирсан хохирлоо арилгуулах Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар олгосон эрхийг хязгаарлаж, мөн “эдийн бус гэм хор буюу хохирлыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөх”-өөр тайлбарласан байна.*

Дээрхи хууль хоорондын зөрчилдөөн нь хохирогчийн эрх зүйн байдлыг гэмт хэрэгтнийхээс доогуур байдалд хүргэж байна.

Тохиолдол 2:

Сүхбаатар дүүргийн прокурорын газраас Р.О, Б.О нарыг эрүүгийн хуулийн тусгай ангийн 124-р зүйлийн 124.2 /Бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулах/, 95-р зүйлийн 95.1/ Бусдыг амиа хорлоход хүргэх/ дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдсэн 2015250000289 тоот эрүүгийн хэргийг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн эрүүгийн шүүх хуралдаанаар 2015 оны 11 дүгээр сарын 19 нд 757/ А шийтгэх тогтоол гарган шийдвэрлэжээ.

Хэргийн товч утга :

Шүүгдэгч Р.О, Б.О нар нь хохирогчийг зочид буудалд оруулж архи уулган хүчээр бэлгийн харьцаанд оруулж биеийг нь үнэлүүлэхэд зуучилж, улмаар түүнийг зодсоны улмаас хохирогч нь амиа хорлохыг завдаж тус буудлын 3 давхрын цонхоор унаж биед нь хүндэвтэр гэмтэл учруулсан гэх гэмт хэрэгт холбогджээ.

Хохирогчийн мэдүүлэг:

Эрүүгийн хэргийн анхан шүүхэд хохирогч мэдүүлэхдээ: Б.О, Р.О нар нь хүчээр архи уулгаж, надад мөнгө олж өг гэж зодсон мөн нэг залуутай унт гэсэн чадахгүй гэсэн чинь дахин зодож аргагүйн эрхэнд тэр хүнтэй унтаад мөнгө төгрөг аваагүй. Дараа нь дахин архи өгсөн. Явуулахгүй байна гээд цонхоор үсэрснээ болон бусад зүйлийг санахгүй байсан.

Би эмнэлэг дээр сэрсэн. Би 23 настай биеэ үнэлж байгаагүй.

Надад гарч явах боломж байгаагүй. Намайг явуулахгүй байсан. Тэнд идэх юм байгаагүй цэвэр ус байсан. Би одоо босож явж чадахгүй тэргэнцэртэй байгаа. Би газарт ар нуруугаараа унасан. Би ажил хийж байгаад хүүхэд гаргаад хүүхдээ хараад гэртээ байсан. Би эмчилгээний зардалд 8.000.000 төгрөгийг нэхэмжилж байгаа. Одоо би босож явж чадахгүй байгаа нуруундаа хагалгаа хийлгэсэн. Аарцаг ясны хагалгаанд орох байсан боловч мөнгөгүй болоод хийлгэж чадахгүй байгаа. Ийм болсондоо гомдолтой байна гэж мэдүүлжээ.

Гэрч С.М мөрдөн байцаалтад мэдүүлэхдээ:

Би хохирогч Г.А-ын эх нь. Миний охин биеэ үнэлж байгаагүй. Би энэ хүмүүсээс 8.000.000 төгрөг нэхэмжилж байна. Охиноо ийм тахир дутуу болгосонд гомдолтой байна. Би охиноо гэмтлийн эмнэлэгт сахиж байсан биен дээр нь зодуурын оромнууд байсан. Бүх бие нь няцралттай байсан. Бид чанар сайтай байх гээд 6.000.000 төгрөгийн боолтыг хийлгэж 8 шрупп тавиулсан. Би ажлаасаа цалингийн зээл авч хагалгаа хийлгэсэн. Бас эд зүйлээ барьцаанд тавьж мөнгөөр нь эмчилгээ хийлгэсэн. Охин маань одоо босож явж чадахгүй группэд орох гэж байгаа. Нялх хүүхэдтэй хэцүү байна. Хохирлоо төлүүлж авах хүсэлтэй байна гэжээ.

Хэргийг шийдвэрлэсэн байдал:

Шүүхээс шүүгдэгч Р.О, Б.О нарыг бүлэглэн зочид буудалд өрөө авч бэлтгээд “орон байраар хангаж” хохирогчийг архи уулган согтоож, биеэ үнэлэгчийг авах гэсэн хүмүүсийг зочид буудалдаа дагуулан ирж хохирогчийг хүчээр бусадтай бэлгийн

харьцаанд оруулж биеийг нь үнэлүүлэхэд зуучилсан эрүүгийн хуулийн тусгай ангийн 124 дүгээр зүйлийн 124.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож Р.О, Б.О нарыг тус бүр 3 /гурав/ жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсэн.

Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 505 дугаар зүйлийн 505.1, 510 дугаар зүйлийн 510.1, зааснаар ялтан Р.О-с 1.500.000 төгрөг, ялтан Б.О-с 1.500.000 төгрөг, Нарлаг дэн буудлаас 1.000.000 төгрөгийг гаргуулж хохирогчид олгохоор шийдвэрлэсэн байна.

Хохирогч Г.А-ын нэхэмжлэлээс 4.000.000 төгрөгийг гаргуулах хууль зүйн үндэслэлгүй учир хэрэгсэхгүй болгож, хохирогч хойшид гарах эмчилгээний зардлаа нотлох баримтаа бүрдүүлж иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэй болохыг дурдсан шийтгэх тогтоол гарсан боловч шүүгдэгч нар давж заалдах шатны шүүхэд хандсан .

2015 оны 12-р сарын 15-ны Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 868 тоот магадлалаар “Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хууль”- ийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасныг баримтлан шүүхээс Р.О, Б.О нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 124 дүгээр зүйлийн 124.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 3 жилийн хорих ялаас тус бүрийг өршөөн хэлтрүүлсэн магадлал гарчээ.

Энэ хэргийн нөхцөл байдлыг үнэлэн үзэхэд дээрхи гэмт хэргийн бүрэлдэхүүн нь эрүүгийн хуулийн тусгай ангийн 113 дугаар зүйл ангид заасан гэмт хэргийн гол

шинж болсон хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, заналхийлсэн үйлдлүүд бодитой үйлдэгдсэн байхад эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.2 дахь хэсэгт зааснаар зүйлчилсэн нь хууль зүйн үндэслэлгүй болжээ.

Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл ангид **2012 оны 1 дүгээр сарын 19 ны өдрийн хуулиар эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсгийн хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх замаар гэснийг “бусдыг” хэмээн өөрчлөлт орсноор хүн худалдаалах гэмт хэргээс ялгах болсон юм.**

Мөн эрүүгийн хуулийн 124-р зүйлийн 124.2 дахь хэсэгт **“Биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, түүнчлэн биеэ үнэлэхэд зуучилсан, биеэ үнэлэхийг байнга зохион байгуулсан, тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлсээр үйлчилсэн”** гэж тодорхой заасан байна. Гэтэл энэ жишээн дээр хохирогчийг зодож гэмтээгээд, хүчээр архи уулгаад, хэл амаар дарамтлан хүнд хүчээр биеийг нь үнэлүүлсэн үйлдлийг анхааран үзээгүй байна.

Тухайн хэргийг шалган шийдвэрлэсэн мөрдөн байцаалтын шат, прокурорын хяналт, шүүхийн анхан шатны шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлал зэрэг нь илт хууль зөрчиж гарсан гэж үзэх үндэслэл байна.

Ийм төрлийн гэмт хэргийн ялгааг нарийвчлан гаргаж тогтоолгүй хохирогчдыг давхар хохироож, гэм буруутай этгээдүүдэд ял завшуулж байгаа нь хүн худалдаалах гэмт хэргийн талаархи хуульчдын мэдлэг зөрүүтэй байгааг харуулж байна.

10. МОНГОЛ ДАХЬ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

Төрийн байгууллага бүтэц , механизм:

2005 онд “Хүн, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг 3 үе шат, 10 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр батлан гаргаснаар ЗГ-ын зүгээс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бодлого тодорхой болсон гэж үздэг. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, гэрээ, конвенцид нэгдэх, энэ чиглэлээр ажилладаг төрийн албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх, олон нийтэд зөв ойлголт мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх зэрэг чиглэлээр олон талт үйл ажиллагаануудыг хийж иржээ.

Тус хөтөлбөрт “хүлээн авагч улсад нь хохирогчийг аврах, хамгаалах, эрх зүйн туслалцаа болон бусад үйлчилгээ үзүүлэх байгууллага, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлж Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон газруудын энэ чиглэлээрх

үйл ажиллагааг идэвхжүүлэх” гэсэн заалт нэмж, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар консулын үйл ажиллагааны эрх зүйн орчинг сайжруулах, шаардлагатай олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэх буюу шинээр байгуулах, энэ хүрээнд дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох” зорилтыг тодорхойлсон нь хохирогч хамгаалалын чиглэлд чухал арга хэмжээ болсон байна.

Мөн бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх, хамгаалах, сэрэмжлүүлэг мэдээлэл гаргах, хэлэлцүүлэг өрнүүлэх, хохирогчдоос мэдээллийг шуурхай авах боломжийг хангасан интернэт сайтыг бий болгож, байнга шинэчлэх” гэж заасны дагуу Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтран www.stoptrafficking.info вэб хуудас нээж ажиллуулж байжээ.

Энэ вэбсайт нь хүн наймаалахтай тэмцэх үйл ажиллагааг төвлөрүүлэн уялдуулах, энэ чиглэлийн төслүүдийн нэгдсэн жагсаалт, үйл ажиллагааны тухай мэдээллийг нийтлэх, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог үүсгэх, холбогдох байгууллагуудын судалгаа, илтгэл, мэдээллийг байрлуулах, цаг үеийн мэдээллийг сурталчлах, иргэдэд зориулан сэрэмжлүүлэг нийтлэх мэдээллийн сан болгох, улмаар яамд, хүчний байгууллага, ТББ-ын хоорондын мэдээллийн сүлжээ болгох, ямарваа хэлбэрээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон, эсхүл энэ талаар мэдээлэл олсон этгээдийн талаар мэдээллийг дэлхийн өнцөг булан бүрээс авах боломжийг бүрдүүлэх зорилт тавьж байсан боловч тогтвортой үйл ажиллагааг нь хангаж чадаагүй байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуульд зааснаар салбар дундын зохицуулалт шаардах тул энэхүү ажлыг уялдуулан зохицуулах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг ГХУСА33-ийн дэргэд ажиллах Дэд зөвлөл хариуцах бөгөөд Дэд зөвлөлийн чиг үүргийг ГХУСА33-ийн ажлын алба хэрэгжүүлэхээр заасан.

Үүний дагуу 2013 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/11 тоот тушаалаар байгуулагдсан байна. Гэвч тус Дэд зөвлөлийн ажлын албыг 2014 оны 8 дугаар сард Хууль зүйн сайдын тушаалаар татан буулгаж, энэ чиглэлийн чиг үүргийг яамны нэг мэргэжилтэнд үндсэн ажилд нь нэмэлт чиг үүрэг болгон хүлээлгэсэн байна.

Иймд 2012 оны 8 дугаар сараас 2016 оны 8 дугаар сарыг хүртэлх 4 жилийн хугацаанд Дэд зөвлөлийн ажил зогсонги байдалд байсан нь ХХГХ-тэй тэмцэх ажил тодорхой төлөвлөгөөтэй, салбар бүрийн оролцоог хангасан, өргөн хүрээг хамарч чадаагүй байна.

Үүнийг дагаад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд үүрэг хүлээсэн бүхий л байгууллагуудын хариуцлага суларч эхэлсэн гэж үзэхээр байв.

Дээрхи хугацаанд ХЗДХЯ нь ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл түгээх, сургалт зохион байгуулах чиглэлээр:

- 2013 онд 30.9 сая,
- 2014 онд 34,3 сая,
- 2015 онд 9,7 сая төгрөгний санхүүжилтийг олгосон байна.

Харин хохирогчид үзүүлэх үйлчилгээний санхүүжилт гаргасан эсэх нь тодорхойгүй байна.

Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг 2005-2015 оны хооронд гурван үе шаттайгаар хэрэгжүүлснээс 1 жил 6 сарын дараа шинэ хөтөлбөр батлагдан гарсан юм.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг ХЗДХ-ийн Сайдын 2016 оны А/83 дугаар тушаалаар байгуулсан байна. ХХГХ-тэй тэмцэх хөтөлбөрийн боловсруулалт болон санал авах шатны хэлэлцүүлгүүдийг ХЗДХЯ-наас зохион байгуулж хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар ажилладаг төрийн болон ТББ-ын төлөөллүүд оролцож санал бодлоо хуваалцжээ.

Энэхүү хэлэлцүүлгийн дараа ТББ-с хөтөлбөрт оруулах саналуудаа бичгээр ажлын хэсэгт өгсөн бөгөөд 2017 оны 5 сарын 24 –ний өдөр ХХГХ-тэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсан.

ХЗДХЯ-ны Сайдын 2017 оны 06 сарын 23 –ны А\173 тоот тушаал гарч ХХГХ-тэй тэмцэх , урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах мэргэжлийн удирдлагаар хангах, ХХТХ-ийн хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүрэг бүхий дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1-р хавсралтаар, дэд зөвлөлийн ажиллах журмыг 2-р хавсралтаар баталсан байна.

ХНХЯ-наас ирүүлсэн мэдээлэлд 2014 онд Хүйсийн тэгш эрхийн төв болон Хүчирхийллийн эсрэг үндэсний төв төрийн бус байгууллагатай хамтран ажилласан байна. Гэвч “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай “Засгийн газрын 2014-оны 05-дугаар сарын 10 –ний өдөр 147 дугаар тогтоол батлагдсанаар 2015 онд төрийн бус байгууллагын үйл ажиллагаа дэмжих чиглэлээр санхүүжилт олгогдоогүй.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12,1,3-т заасан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжилийн сургалтанд хамруулан, хуулийн хэрэгжилтийг хангах үүргийг хүлээнэ¹⁰. гэжээ.

Улсын хэмжээнд хохирогчийг илрүүлэх үүрэгтэй эрүүгийн төлөөлөгч Эрүүгийн Цагдаагийн газарт хоёр төлөөлөгч ажиллаж байсан бол 2014, 2016 онд ганцхан төлөөлөгч хариуцан ажилласан¹¹.

2008-2013 онд жилд 10 гаруй хэрэг шалгагддаг байсан бол

- 2014 онд - 8,
- 2015 онд - 6,
- 2016 онд - 3 хэрэг бүртгэгдсэн¹² байна.

Дээрхи хэргийн тоо буурсан явдал нь ХХГХ-тэй тэмцэх дэд зөвлөлийг татан буулгаж, үндэсний хөтөлбөр батлах үйл явц удааширсантай холбоотой.

Төрийн бус байгууллагуудын гүйцэтгэж буй үүрэг:

Улсын хэмжээнд нийт 23258 төрийн бус байгууллага бүртгэгдсэн боловч 80 гаруй хувь нь Улаанбаатар хотод төвлөрсөн бол дөнгөж 19% нь орон нутагт үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн байна.¹³ Бүртгэлийн статистик мэдээнээс үзэхэд нийт төрийн бус байгууллагуудын 85.4% нь нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага байна. Гэвч зөвхөн зөвхөн 1 % нь тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.¹⁴

¹⁰Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамны 2017.02.07-ны 9/380 тоот оос

¹¹Хүний аюулгүй байдлын төвөөс зохион байгуулсан “Хүн худалдаалахтай тэмцэхэд хуулийг хэрэгжүүлэх нь” Зөвлөлдөх уулзалтын үеэр ЦЕГ-ын ЗБГХТГ-ын хэлтсийн дарга, Цагдаагийн дэд хурандаа Д.Очгэрэлийн тавьсан илтгэл, 2015 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр, Улаанбаатар хот.

“Хүн худалдаалахтай холбоотой хууль, тогтоомж” хэлэлцүүлгийн үеэр ЭЦГ-ын ахлах төлөөлөгч н.Төмөрбаттай хийсэн уулзалт. 2017 оны 2 сарын 15-ны өдөр, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Улаанбаатар хот.

¹²ЭЦГ-аас 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдөр Иргэдэд туслах хүний эрхийн төвд ирүүлсэн 13/720 албан тоотын хавсралт.

¹³Хуулийн эдгээдийн улсын бүртгэлийн тоон мэдээлэл, 2016 он

¹⁴Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон мэдээлэл, 2016 он

Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлд 20 орчим ТББ идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нэгдсэн зохион байгуулалтанд орж хүний наймаатай тэмцэх ТББ-дын сүлжээ байгуулан 3 жил орчим ажиллаж байна.

Энэхүү сүлжээ нь 2014-01-23 –нд Европын Холбооны дэмжлэгтэй дэмжлэгтэйгээр Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Каритас Чех Байгууллагыг хэрэгжүүлсэн “Хүн худалдаалахтай тэмцэхэд иргэний нийгмийг бэхжүүлэх нь төсөл”-ийн хүрээнд 19 гишүүн байгууллага нэгдэн ажиллаж эхэлсэн байна. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхэд ТББ-уудын хамтын ажиллагааг хөгжүүлж, дэмжин ажиллах зорилготой.

Энэ зорилгын хүрээнд сүлжээний гишүүн байгууллагуудыг чадавхижуулах зорилгоор сургалт, уулзалт, хэлэлцүүлэг хийхээс гадна улирал тутам цахим сонин гаргах, фасевоок хуудас ажиллуулах, мөрдөн байцаагч, прокуроруудад сургалт хийж, хуульчдын дунд зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулжээ.

“Гинжийг тасалъя” 1000 хүний нөлөөллийн марафон зохион байгуулсан. Улаанбаатар, Дорнод, Өмнөговь аймгийн төвүүдэд хүүхэд залуучуудын дунд сургалт, өдөрлөг хийж нийгмийн сүлжээгээр 3 шторк, мэдээлэл цацсан нь 15000 хүний хандалттай байна.

Баримтат нэвтрүүлгийг телевизийн 3 сувгаар явуулж ,НҮБ-с жил бүр зохион байгуулдаг “Хөх Зүрх” -ний аянд нэгдэж хүүхэд залуучуудыг ХХГХ-с урьдчилан сэргийлэхийг уриалсан үйл ажиллагаанууд явуулж.давхардсан тоогоор 20 гаруй хохирогчдод нийгмийн үйлчилгээ үзүүлж, 8 хохирогчтой 3 хэргийг шүүхээр амжилттай шийдүүлсэн байна.

ХХГХ-ийн талаархи бодлого, хуулийн хэрэгжилтэнд дэмжлэг, нөлөөлөл үзүүлэх зорилгын хүрээнд ХХГХ-ийн асуудлаар ажилладаг хуульчдад зориулсан гарын авлага боловсруулан гаргаж хуульчдад тараасан. Шинээр батлагдан гарсан үндэсний хөтөлбөр болон хуулиудад 30 гаруй санал гаргаж холбогдох яам тамгын газруудад хүргэсэн байна¹⁵.

Дээрхи сүлжээ байгууллагын гишүүн ЭКПАТ Монгол ТББ нь Өмнөговь, Дорноговь аймгийн 5 сум, хилийн боомт орчимд уул уурхай болон зам тээврийн салбарт ажиллаж байгаагаас бусдаар хөдөө орон нутагт хүрч ажиллаж чадахгүй байна.

Статистик мэдээллээс дүгнэхэд төрийн болон орон нутгийн байгууллагаас тодорхой асуудлаар төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллах хүрээ, санхүүжилт жилээс жилд тодорхой хэмжээнд өссөн боловч энэхүү

¹⁵ ХАБСТ-ийн хөтөлбөрийн менежер Ж.БАТЗАЯА
2017.2.15 ны ХХГХ-ийн талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал хэлэлцүүлэг

түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний дийлэнх хувийг байнгын бус нэг удаагийн шинжтэй гарын авлага, мэдээлэл боловсруулах, сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа багтаж байна.

Хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, НҮБ-ын Хүний эрхийн хороодод тайлан хүргүүлэх, шийдвэр гаргагчдад болон олон нийтэд чиглэсэн нөлөөллийн болон сургалт, сурталчилгаа, судалгааны ажил гүйцэтгэх, холбогдох мэргэжилтнүүдийг бэлтгэх чиглэлээр Хүйсийн тэгш эрхийн төв, Хүний наймаатай тэмцэх ТББ-ын сүлжээ, ЕСПАТ Монгол ТББ, Хүний Эрхийн Төрийн Бус Байгууллагуудын Форум, Иргэдэд туслах хүний эрхийн төв Хүний эрх, хөгжил төв, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Хүүхдийн эрхийн үндэсний төв, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Эмэгтэй удирдагч сан зэрэг байгууллагууд ажиллаж байна.

Түүнчлэн дээрх нөлөөллийн үйл ажиллагаанаас гадна хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг давхар гүйцэтгэдэг Хүйсийн тэгш эрхийн төв, ЕСПАТ Монгол ТББ, Иргэдэд туслах хүний эрхийн төв, Хүүхдийн Өмгөөлөл Төв, Хүүхдийн Эрхийн Үндэсний Төв, “Монгол Өрх” сэтгэл судлалын төв зэрэг ТББ-ууд байна.

Харин орон нутагт ажиллах төрийн бус байгууллагуудыг дэмжих бодлого сулаас төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх тохиолдол хөдөө орон нутагт дутмаг байна. Төрийн чиг үүргийг шилжүүлэн гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагуудын хувьд ч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд олон хүндрэл үүсдэг байна.

Хүн худалдаалах чиглэлээр ажилладаг ТББ-уудын дийлэнх хувь нь судалгаа, мэдээлэл, сургалт зохион байгуулах, нөлөөллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бол хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх болон хууль зүйн тусалцаа үзүүлэх чиглэлээр цөөн хэдхэн байгууллага ажиллаж байна.

Улсын хэмжээнд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалан байрлуулах үйлчилгээг Хүйсийн тэгш эрхийн төв, Талита-Ази, Цөлийн гол гэсэн 3 ТББ байгууллага үзүүлж байна. Эдгээр ТББ-дад тогтмол санхүүжилт байдаггүй. Олон улсын байгууллагын тусламж дэмжлэг, төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа нь хохирогчдод тогтмол чанартай үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл үзүүлж байна.

Хуульд зааснаар хохирогчид үзүүлэх үйлчилгээг төрөөс санхүүжүүлэх ёстой боловч дийлэнх зардлыг ТББ-ууд гадны төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна.

Нэг хохирогчийг хамгаалан байрлуулахад дунджаар нэг сард 3.850.000 төгрөг зарцуулдаг байна. ¹⁶ Гэтэл ХЗДХЯ-наас хамгаалах байрны үйлчилгээнд зориулж 2013-2014 онд 5 сая, 2014-2015 онд 7 сая төгрөгний санхүүжилт гаргажээ.

Харин ХЗЯ-наас Хүйсийн Тэгш Эрхийн Төв ТББ-гаар 2013-2015 онд 21 аймгийн Цагдаагийн байгууллагад ХХГХ-ийн талаархи сургалтыг гэрээлэн гүйцэтгүүлсэн бөгөөд сургалтанд зориулж 2013-2014 онд 9 сая, 2014-2015 онд 11 сая төгрөгийг Хууль зүйн сайдын багцаас гарган хэрэгжүүлжээ.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.2-ийн дагуу хохирогчийг хамгаалан байрлуулахад НХХЯ-наас санхүүжилт авахаар ханддаг ч үйлчилгээний 1 сарын тариф нь 11900 төгрөг байдаг.

Энэ нь зөвхөн хоол хүнс, ахуйн хэрэглээнээс хэтрэхгүй хэмжээтэй тул хохирогчийг чадавхижуулах чиглэлээр үйлчилгээ үзүүлэх боломжгүй болдог байна.

Манай байгууллага халамжийн үйлчилгээний чиглэлээр төртэй гэрээлэн ажилладаг. Санхүүжилт нь үйлчилгээ үзүүлсний дараа буюу гүйцэтгэлээр нөхөн олгодог тул бидэнд мэргэшсэн, арга зүйн туршлагатай байхаас гадна суурь санхүүгийн нөөцтэй байж төртэй хамтран ажиллах шаардлага тулгардаг. Өөрөөр хэлбэл бизнесийн байгууллагатай адил болзол хангах шаардлагатай болдог. Зардлаа нөхөн авахын тулд олон тооны бичиг баримт бүрдүүлж, урт хугацааны турш, олон шат дамжлага туулахад хүрдэг талаар Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн ажилтан ярьсан юм.

ТББ-ын төлөөлөгч Хүйсийн тэгш

Хохирогчид шууд туслалцаа үзүүлдэг ТББ-ын ажилтнуудын аюулгүй байдлын хамгаалалт хохирогчийн нэгэн адил өндөр эрсдэлтэй байдаг ч энэ талаар төрөөс анхаарал хандуулдаггүй. Зөвхөн үйлчилгээний шууд зардлыг гаргахаас бус ажилчдын цалин хөлс тэр ч бүү хохирогчийн аюулгүй байдалд шаардлагатай зардлыг камерийн хамгаалалт, гэрээт харуул хамгаалалтын зардал зэргийг төрөөс гаргадаггүй.

Энэ мэт бэрхшээлээс хамаарч хохирогчийг хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэхээс ТББ-ууд татгалзаж болзошгүй байгаа нь энэхүү судалгааны явцад хийгдсэн ярилцлагын үеэр хөндөгдөж байсан.

Олон талт хамтын ажиллагаа ба зохицуулалт:

Олон нийт хүн худалдаалах гэмт хэргийг ихэвчлэн биеийг нь үнэлүүлэх, эсхүл эд эрхтнийг нь авах зорилгоор хулгайлан хил дамжуулан худалдах хэмээн ойлгож

¹⁶ ХТЭТ-ийн мэдээлээс

байна. Харин дотоодод ихээр үйлдэгдэж байгаа хөдөлмөрийн мөлжлөгийн талаар ойлголтуугаас хохирогч болох нь түгээмэл байна. Энэ байдал нь Монгол Улсад гэрээгээр хөдөлмөр эрхэлж буй гадаад ажилчдад ч хүндээр тусч байна.

Тухайлбал, Өнөөдөр манай улсад цөөнгүй гадаадын иргэн хөдөлмөр эрхэлж байгаагийн дийлэнх хувийг БНХАУ, БНАСУ-ын иргэд эзэлж байна.

Хэдийгээр хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ болон Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай Монгол Улсын хуулийн хүрээнд ажилчдын тоо, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, нөхцлийг тогтоож байгаа боловч хууль болон гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул, хяналт тавих үүрэгтэй байгууллагуудын хариуцлага, хамтын ажиллагаа үр дүнгүй, ажил олгогч тал үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байгаагаас эдгээр иргэдийн эрх олон хэлбэрээр зөрчигдөж байна.

2016 онд гадаадын иргэдийг гэрээгээр ажиллуулж буй 7 компани, 500 орчим гадаад ажилтныг хамруулсан шалгалтаар¹⁷ тэдгээр иргэдийн ажиллах, амьдрах нөхцөл нь эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй, хоол хүнсний чанар, хүртээмж хангалтгүй, эрүүл мэндийн үзлэгт хамруулдаггүй зэрэг олон зөрчил илэрсэн.

Эдгээр гадаад ажилчид өөрсдөө ямар эрхтэй болох, эрх нь зөрчигдсөн тохиолдолд хаана, хэрхэн хандах талаар ойлголт, мэдлэггүй байна.

“Тэлмэн констракшин” ХХК нь БНАСАУ-ын 176 ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж 90 000¹⁸ төгрөгийн цалин авч байгаа нь өнөөдөр Монгол Улсад мөрдөгдөж байгаа амьжиргааны баталгаажих доод түвшний 50%-д ч хүрэхгүй байна.¹⁹

Хүн худалдаалахтай гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны санхүүжилтийг улс, орон нутгийн төсвөөс бүрдүүлэх бөгөөд энэхүү хөрөнгийг зөвхөн дараахь зориулалтаар зарцуулахаар заажээ:

- Хамгаалах байрны үйл ажиллагааг санхүүжүүлэх;
- Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын, шалтгаан, үр дагаварын талаар мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагаар судалгаа хийлгэх;
- Хүн худалдаалахтай тэмцэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа явуулах;

¹⁷ХЗДХЯ-аас хийсэн шалгалт.

¹⁸ Мэргэжлийн Хяналтын Газрын 2015 оны 1 сард хийсэн шалгалт

¹⁹Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/9 тоот тушаалаар 2015 онд Улаанбаатар хотод амьжиргааны баталгаажих доод түвшин 183,700 төгрөгөөр тогтоогдсон байна.

- Хүн худалдаалахтай тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулсан иргэн, ААН, байгууллага, албан тушаалтныг урамшуулах;
- Хүн худалдаалахын эсрэг үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэх гэжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1-д заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг гадаад улс, олон улсын байгууллагын хандив, тусламж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлуулсан хөрөнгө, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдүүлэх бөгөөд энэхүү хөрөнгийг зөвхөн дараахь зориулалтаар зарцуулахаар заажээ:

Үүнд:

- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллагуудаас иргэд, байгууллагын дунд зохиож байгаа сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх;
- эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлж яваад хохирсон иргэний тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх;
- цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх;
- гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай цагдаагийн байгууллага иргэдээс мэдээлэл авах төлбөрийн зардлыг хамаарч байна.

Үүнээс үзэхэд хууль хоорондын зөрчил үүсч Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан “тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө”-өөс ХХГХ-ийн хохирогчийг хамгаалан байрлуулах үйлчилгээг санхүүжүүлэх боломжгүй болж байна.

11. **ХОХИРОГЧ ХАМГААЛАЛ БА ГЭМТ ХЭРЭГТЭНД ХАРИУЦЛАГА ОНОГДУУЛЖ БУЙ БАЙДАЛ.**

Хохирогчийг олж тогтоох

Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, хохирогчийг олж тогтоох ажиллагаа нь бусад төрлийн гэмт хэргийг илрүүлэхээс илүү нарийн ур чадвар, өргөн цар хүрээг хууль хэрэгжүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдээс шаарддаг.

Гэвч манай улсын хувьд энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт хангалтгүй байгаа явдал нь:

1. гэрч, хохирогч, мэдээлэгчийн нууцлал, аюулгүй байдлыг хангах тогтолцоо сул;
2. иргэдэд үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн алба хаагчдын хувьд хохирогчийг олж таних, тэдэнтэй холбоо тогтоох ур чадвар сул, мэдээллийг холбогдох хууль хяналтын байгууллагад хүргэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт байхгүй;
3. хохирогчид үзүүлэх үйлчилгээ, хамгаалалт бодит байдалд хэрэгждэггүй, хохирогч хамгаалалт авахын тулд олон эрсдлийг даван туулах шаардлагатай болдог зэрэгтэй холбоотой хэмээн дүгнэж болох юм.

Учир нь энэхүү гэмт хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдэхээс гадна гэмт этгээдүүд хохирогчийг бүхий л талаар өөрийн эрхшээл, хараа хяналтанд байлгадаг.

Хохирогч гэмт этгээдүүдээс зугатааж чадсан хэдий ч айдсаас хамаарч тэдний эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэргийн талаар үнэн бодит байдлыг илчлэхээс айж байдаг.

Иймд энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, хохирогчдыг олж тогтооход хууль сахиулагчдын ур чадвараас гадна иргэд, олон нийтийн оролцоо, мэдээлэл нэн чухал юм.

Өөрөөр хэлбэл иргэд энэ гэмт хэргийн талаарх зөв ойлголт, мэдлэгтэй байх нь хохирогч болохоос урьдчилан сэргийлэхээс гадна сэжигтэй тохиолдлын талаар мэдээлэх боломжтой болно.

Үүний тулд иргэдээс ирэх мэдээллийг тэдэнд чирэгдэл багатай хүлээн авах, мэдээлэгчийн нууцлалыг хадгалах, шаардлагатай бол мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах үр дүнтэй арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо шаардлагатай юм.

Хэдийгээр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт "...гэмт хэргийг илрүүлж, таслан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдүүлэг өгсөн гэрч болон уг гэмт хэргийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэний аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнийг энэ хуульд заасан хохирогчийг хамгаалах арга

хэмжээнд хамруулж болно.” гэж заасан боловч бодит байдалд хохирогчийн нэгэн адил хамгаалалтгүй хэвээр байна.

Өөрөөр хэлбэл, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч, гэрч нь мэдээлэл өгсөн цагаасаа бус харин 5-19 хоногийн дотор²⁰эрүүгийн хэрэг үүсгэж, улмаар хохирогч, эсхүл гэрчээр тогтоосон тухай мөрдөн байцаагчийн тогтоол гарсны дараа энэхүү хамгаалалтад хамрагдах боломжтой болдог байна.

Жич: Энэ нь гэрч, хохирогчийг хамгаалах тухай болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль хоорондын зөрчилдөөн бүхий зохицуулалтаас хамаарч байгаа талаар Үнэлгээний тайлангийн..... хуудаснаас дэлгэрүүлж үзнэ үү.

Түүнчлэн 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх, прокурор, мөрдөгч хохирогчоор тогтоох тухай шийдвэр гаргана”, гэсэн нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хамгаалалтыг хуулийн байгууллагад мэдээлэл хүргэгдэж, улмаар хэрэг бүртгэлт, эсхүл мөрдөн байцаалтын ажиллагаа эхэлсэн нөхцөлд л гэрч, хохирогч хамгаалалт авах боломжтой болж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээллийг хүлээн авах, хохирогчийг хэрэгцээтэй хамгаалалт, үйлчилгээтэй холбон зуучлах, зөвлөгөө өгөх зорилго бүхий “1903” дугаарын утсыг мэргэшсэн ТББ-ын дэргэд /Хүйсийн тэгш эрхийн төв/ .2005 оноос ажиллуулж эхэлсэн боловч төрөөс үзүүлэх ямар нэгэн хамгаалалт, санхүүгийн дэмжлэггүй байдлаас шалтгаалан 2016 оноос зогсооход хүрчээ.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын хувьд хуулийн байгууллагад хандахаас илүү шаардлагатай үйлчилгээнд хамрагдахын тулд эрүүл мэндийн болон нийгмийн халамж, хамгаалал, боловсрол, хүүхдийн гэх мэт төрийн үйлчилгээний байгууллага, мэргэжилтнүүдэд тэргүүнд ээлжинд хандаж байдаг.

Гэтэл эдгээр мэргэжилтнүүд хохирогчийн талаар мэдсэн, эсхүл мэдэх боломжтой байсан ч тухайн асуудалд анхаарал хандуулдаггүй. Өөрөөр хэлбэл эдгээр мэргэжилнүүдийг ХХГХ-ийн талаар сургалт, мэдээлэлд хамруулдаггүй төдийгүй албан үүргийнхээ дагуу гэмт хэргийн талаарх мэдээллийг заавал өгөх үүргийг хуулиар хүлээдэггүй байна.

Тэдний хувьд мэдээлэл өгөх шаардлагыг хохирогчийн аюулгүй байдал, хамгаалалтыг хангах суурь асуудал гэдгээр бус бусад төрлийн үйлчлүүлэгчидтэй адилтган “үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах, итгэлийг хүлээх” үүрэг хэмээн үзэх буруу ойлголт, хандлагаас хамаарч мэдээлэл өгөхөөс татгалздаг байна.

²⁰Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 171 дүгээр зүйл. Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хянан үзэх хугацаа

.... Хохирогч өөрөө хүсэлт гаргаагүй бол бид мэдээллийг хуулийн байгууллагад өгөх нь буруу гэж боддог. Хэрэв хүсвэл хохирогч өөрөө хуулийн байгууллагад мэдээлэл өгч чадна шүү дээ...

Эмэгтэйчүүдийн эмчтэй хийсэн -2017 оны ярилцлагаас

Энэ нь хохирогчийг айдас, дарамтанд үлдээхэд хүргэж байна.

Иймд энэ чиглэлийн мэргэжилтнүүд цагдаагийн байгууллагад мэдээлэл өгөхөөс гадна хохирогчдыг өөрийгөө хамгаалах, хаанаас, ямар тусламж, үйлчилгээ авч болох талаар мэдээллээр хангах чиг үүргийг давхар хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Харин цөөн тооны хохирогчдын хувьд энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг ТББ-уудад хандснаар үйлчилгээ авч байна.

Гэвч ТББ-уудын санхүүгийн болон хүний нөөцийн байдлаас хамаарч хязгаарлагдмал хүрээнд үйлчилгээ явагдаж байна. Түүнчлэн төвөөс алслагдмал, хөдөө орон нутгийн хохирогчдын хувьд төр, төрийн бус байгууллагын аль альны үйлчилгээнд хамрагдаж чадахгүй хэвээр байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг Хүйсийн тэгш эрхийн төв /ХТЭТ²¹/-ийн үйлчилгээ, түүнд гаргасан өртөг зардлыг тооцооллоос дүгнэхэд хохирогч болгонд гаргаж буй зардал харилцан адилгүй байна.

Хохирогчтой ажиллахдаа хохирогч тус бүрт эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрийг боловсруулдаг. Энэ хөтөлбөрийн дагуу хохирогч үйлчилгээнд хамрагддаг ба нийгмийн ажилтан, хуульч, эрүүл мэндийн ажилтан нар багаар ажилладаг байна. 6 эрүүгийн хавтаст хэргийн хохирогчид бүгд тус төвд хандаж өмгөөлөл болон бусад үйлчилгээнд хамрагдсан байна.

Төрийн бус байгууллага ялангуяа үйлчилгээнд суурилсан үйл ажиллагаа хэрэгжүүлдэг байгууллагаас нэг хохирогчдод гаргаж буй зардлыг тооцон үзэхэд дунджаар 8 201 400 төгрөгний зардал гарчээ.

Хамгаалах байрны²² зардлыг талаар 2010 онд боловсруулсан бодлогын баримт бичгээс үзэхэд нэг хохирогчдод нэг сар 3 850 000 төгрөг зарцуулж байна. Энэ зардалд ажилтны цалин болон урсгал зардлууд оржээ. Хүйсийн тэгш эрхийн

²¹ХТЭТ-өөс хохирогчдод нийгэмшүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлдэг байна. Энэхүү хөтөлбөр нь хохирогчдод үзүүлэх үйлчилгээг санхүүгийн тооцоотой нь хамт боловсруулж, батлан хэрэгжүүлдэг байв. Ингэснээрээ хохирогчийг нөхөн сэргээхэд гаргаж буй зардлыг тооцоход хялбар байлаа.

²²

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод зориулсан хамгаалах байрны тогтвортой үйл ажиллагааг хангах төлөвлөгөө, Хүйсийн тэгш эрхийн төв, 2010 он

төвөөс хохирогчдыг эх орондоо эргүүлэн авчрах, эрүүл мэнд, хууль эрхзүй, нийгэм сэтгэлзүй, анхан шатны болон нөхөн сэргээх зардалд 52,831,708 ²³ төгрөгийг зарцуулсан байна.

Судалгаагаар Хүн худалдаалах гэмт хэргийн 6 хэргээс үзэхэд өмгөөллийн зардлыг ихэвчлэн төрийн бус байгууллага гаргасан ба ялангуяа хохирогчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаанд 1 000 000 төгрөгөөс 3 500 000 төгрөгийг зарцуулсан байна.

Судалгаагаар энэ төрлийн гэм хэргийг хянан шийдвэрлэх хугацаа нийт судлагдсан хэргүүдээс дунджаар нэг хэргийн нэг хохирогчтой эрүүгийн хэргийг 40 сарын хугацаанд шалгагдсан байна.

Үүнээс дүгнэхэд хүн худалдаалах гэмт хэргийн өмгөөлөгч нь зохион байгуулалтай бүлгийн эсрэг үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалан ажилладаг тул эрсдэлтэй нөхцөлд байхаас гадна хохирогч төлбөрийн чадваргүй тул маш бага зардлаар ажиллахад хүрдэг. Мөн хүн худалдаалах нэг гэмт хэргийн цаана дунджаар 3-10 хохирогч байдаг тул өмгөөлөгч асар их ачаалалтай ажиллахад хүрдэг.

Гэвч энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг цөөн тооны өмгөөлөгч ТББ-д ажиллаж байна.

Хохирогчийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд олон дэвшилттэй зохицуулалт туссан боловч **холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлтийг хийгээгүйгээс хэрэгжих боломжгүй байна.**

Тухайлбал, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6.2-т зааснаар БСШУСЯ нь “хүн худалдаалахын хор уршиг, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, тайлбарлан таниулах талаар ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөр, стандартад тусгах” үүргийг хүлээсэн боловч Боловсролын багц хуульд энэ чиглэлээр тодорхой заалт байхгүй, өнөөг хүртэл суурь болон бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт энэ чиглэлээр агуулга тусгагдаагүй байна.

Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах үйл явц:

Мөрдөн байцаах ажиллагаа нь тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх, гэмт хэргийн шалтгаан, үйлдэгдсэн байдал, байршил, хугацааг илрүүлэх, хохирогч, гэрчийг олж

²³ ХүйсийнтэгшэрхийнтөвтББнь 2007 оноосэхлэнОУШХБ, АНУ-ынТөрийнДепартамент, 2008-2011 ондШХА, 2014 оноосЕХ-тойхамтранХХГХ-ийнхохирогчдодшуудтуслалцааүзүүлэххөтөлбөр, төслүүдийнхэрэгжүүлэнажиллаж байна.

тогтоох, хамгаалах, нотлох баримтыг цуглуулах, хадгалахад чиглэгдсэн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх цогц ажиллагаа юм.

Мөрдөн байцаах ажиллагааг тухайн гэмт хэргийн болон хохирогчийн онцлогоос хамаарч нарийвчилсан үе шат, тактикаар хэрэгжүүлэх шаардлага тулгардаг.

Тухайн гэмт хэргийг шалгах ажиллагаанд гэрч, хохирогчийн оролцоо, хандлага хэр байгаагаас хамаарч мөрдөгчийн ажиллах арга барил, явуулах ажиллагаа өөр өөр байдлаар төлөвлөгдөж болно.

Өөрөөр хэлбэл хохирогч хэдий чинээ айдас, дарамтаас ангид, хамгаалалтанд байна төдий чинээ хууль сахиулах байгууллагад итгэх, хамтран ажиллах эрмэлзэл бий болдог.

Иймд мөрдөн байцаагчийн хэрэгжүүлэх ажиллагааны эхний шатанд хохирогчтой харилцах болон хамгаалалтаар хангах ажиллагаа хамаарна.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд мэдүүлэг авах ажиллагааг зориулалтын тусгай өрөөнд авахаар хуульчилсан нь тоноглогдсон гэхээс гадна мэдүүлэг өгч байгаа хүний нэр төр, алдар хүнд, хэргийн нууцлалыг алдагдуулахгүй байхад чиглэгдэж байна. Түүнчлэн хохирогч, гэрчийг өөрийнх нь зөвшөөрснөөс бусад тохиолдолд яллагдагчтай нүүрэлдүүлэн байцаахгүй байхаар хуульчилжээ.

Харин гадаад улс оронд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болоод олон улсын байгууллагын тусламж болон бусад ямар нэгэн аргаар эх орондоо ирсэн хохирогчдод туслах тэднийг эргэж хэвийн амьдралдаа ороход нь дэмжлэг үзүүлэх, гэм буруутай этгээдэд ял шийтгэл оногдуулсан эсэх талаархи мэдээлэлийг авч хохирогчдод болон олон нийтэд мэдээлэх явдал орхигдсон хэвээр байна.

Нотлох баримт цуглуулах:

ХХГХ-ийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцад байцаах, нүүрэлдүүлэн байцаах, таньж олуулах, хураан авах, үзлэг, нэгжлэг хийх, туршилт, шинжилгээ болон ЭБШХ-д заасан бусад байцаан шийтгэх ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулж ирсэн. Өнөөдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар ч энэхүү зарчим хэвээр хадгалагдсан.

Хүн худалдаалах гэмт хэргийн хувьд далд, зохион байгуулалттай, гэрчгүй үйлдэгддэг тул мөрдөн байцаах ажиллагаанд хохирогч, гэрч, өмгөөлөгчийн зүгээс гаргаж өгсөн нотлох баримт чухал үүрэг гүйцэтгэдэг.

Гэтэл мөрдөн байцаагч хэрэгт ач холбогдолгүй, хамааралгүй гэх үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, хүсэлтийг хангах боломжгүй гэдэг үндэслэлээр хэрэгсэхгүй болгох, үүнийгээ хавтаст хэрэгт тусгахгүй зэргээр гэрч, хохирогчийн эрхийг нь зөрчиж ирсэн.

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт “Хохирогч, яллагдагч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргаж өгсөн баримт бичиг, гомдол, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурор авч хавтаст хэрэгт тусгаж хавсаргана.” гэсэн нь тухайн **баримтыг хэрэгт хамааралтай эсэхийг үл харгалзан хавтаст хэрэгт заавал тусгахаас гадна хавсаргах үүргийг мөрдөгч болон прокурорт хүлээлгэсэн байна.**

Энэхүү зохицуулалт нь хавтаст хэрэгт тусгагдсан нотлох баримтыг шүүх шинжлэн судалж, шийдвэрийнхээ үндэслэл болгох эсэхийг шийдвэрлэх боломжийг өргөтгөснөөс гадна тухайн нотлох баримтыг шүүхээр үнэлүүлэх боломжийг олгож байгаа нь чухал ач холбогдолтой зохицуулалт болсон байна.

Мөн хуулийн 16.3 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт “ Шүүх хавтаст хэргийн материалд тусгагдсан мэдүүлгийг шүүх хуралдаанд өгсөн мэдүүлэгтэй харьцуулан шүүхийн шийдвэрийн үндэслэл болгох эсэхийг шийдвэрлэнэ” гэжээ.

Өөрөөр хэлбэл хавтаст хэрэгт тусгагдсан мэдүүлгийн алийг нь нотлох баримтаар тооцохыг шүүх нь шүүх хуралдаанд өгсөн мэдүүлэгтэй харьцуулан шийдвэрийнхээ үндэслэл болгох эсэхийг шийдвэрлэх боломжтой болж байна. Жишээ нь гэрч нь хэрэг бүгтгэлт, мөрдөн байцаалтанд өгсөн мэдүүлгээс өөр мэдүүлэг өгсөн тохиолдолд шүүх нь хуралдааны явцад нотлох баримтыг шинжлэн судалж, шийдвэрийнхээ үндэслэл болгох эсэхийг тогтооно гэсэн үг юм.

Энэ нь гэрч хөндлөнгийн нөлөөнд орж, мэдүүлгээс буцсан хэдий ч шүүх өмнөх нөхцөл байдал, мэдүүлэгт тулгуурлан шийдвэр гаргах тул хохирогчийн эрхийг хамгаалахад ашиглагдах зохицуулалт хэмээн үзэж болохоор байна.

Сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг өгөх үйл явц:

Энэ төрлийн гэмт хэргийг шалгах ажиллагааны явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангах нэг хэлбэр нь сэжигтэн, яллагдагчид авах таслан сэргийлэх арга хэмжээг оновчтой тогтоох байдаг.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд /2002 он/

- оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах
- батлан даалтад өгөх
- эд хөрөнгө барьцаалах
- цагдан хорих гэсэн таслан сэргийлэх арга хэмжээг хуульчлан хэрэгжүүлж ирсэн.

Өөрөөр хэлбэл ХХГХ-ийн сэжигтэн, яллагдагчийн хувьд хохирогчид нөлөөлөх, дарамт үзүүлэх байдлыг дээрх таслан сэргийлэх арга хэмжээнээс зөвхөн “цагдан хорих” нөхцөлд л хязгаарлаж болохоор байсан.

ЭБШХ-ийн 68 дугаар зүйлд зааснаар

1. хүнд, онц хүнд гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдэн бол;
2. хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдсэн бол **цагдан хорих** арга хэмжээг оногдуулдаг байсан.

Өөрөөр хэлбэл дараахь үндэслэлээр ХХГХ-ийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих боломжтой байсан.

113 дугаар зүйл. Хүн худалдаалах		Цагдан хорих үндэслэл
113.1	Хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, түүнчлэн өөр хүнийг эрхшээлдээ байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, ашиг олгон хахуульдах аргаар хүнийг хүн худалдаалах гэмт үйлдэлд элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан бол	<ul style="list-style-type: none"> - Өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн - Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болзошгүй - Оргон зайлсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдсэн бол
113.2	Энэ хэргийг 113.2.1. давтан 113.2.2.хоёр буюу түүнээс олон хүнийг 113.2.1.насанд хүрээгүй хүнийг 113.2.4.хүний эд эрхтэнг авах зорилгоор 113.2.5.сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чаздамжгүйд тооцогдсон хүнийг 113.2.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг 113.2.7.албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг 113.2.8.хуурамч бичиг баримт ашиглах 113.2.9.хохилогчийн бичиг баримтыг авах, нуух, устгах арга хэрэглэж 113.2.10. улсын хил давуулан 113.2.11.илтэд жирэмсэн хүнийг худалдаалсан бол	<ul style="list-style-type: none"> - Хүнд гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч бол - түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд бол
113.3	Энэ хэргийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол	<ul style="list-style-type: none"> - онц хүнд гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч бол - онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдэн бол

Үүнээс дүгнэхэд манай улсын хувьд хамгийн ихээр үйлдэгддэг хөдөлмөрийн мөлжлөг болон дотоодод үйлдэгдэг бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг цагдаагийн байгууллагаас шалгах явцад тухайн гэмт этгээдийг “оргон зайлж болзошгүй” гэхээс бусад үндэслэлээр буюу бодит байдлыг тогтооход саад учруулж болзошгүй нөхцөлд цагдан хорих боломжгүй байсан.

Цагдан хорих арга хэмжээ авах үндэслэл болох “оргон зайлж болзошгүй” гэдгийг тухайн этгээдийн оршин суух хаяг тодорхойгүй, эсхүл эрхэлсэн тодорхой ажилгүй, урьд өмнө оргон зайлж байсан зэрэг нөхцөлийг хамааруулж практикт хэрэглэдэг байсан.

Гэтэл бодит байдалд хөдөлмөрийн мөлжлөг болон биеийг нь үнэлүүлэх хэлбэрээр бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг үйлдэгчид нь ихэвчлэн гэмт төрхөө халхавчилсан өөрсдийн гэсэн аж ахуйн нэгж, үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаг этгээд байдаг байна.

Энэ нь цагдан хорих талан сэргийлэх арга хэмжээнээс зайлсхийж, улмаар чөлөөтэй байх боломжийг олгож, хуулийн байгууллагад хандсан ч хохирогчийн хувьд гэмт этгээдийн дарамт, шахалтаас ангид байж чадахгүйд хүргэдэг байсан.

Харин 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хувийн баталгаа гаргах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, цагдан хорихоос гадна “**хязгаарлалт тогтоох**” гэсэн өргөн агуулга бүхий таслан сэргийлэх арга хэмжээг шинээр хуульчилсан, мөн эдгээр арга хэмжээг **давхардуулан авч болохоор**²⁴ заасан нь дэвшилттэй байна.

ЭХХШТХ-ийн 14.5 дугаар зүйлд “**Хязгаарлалт тогтоох**” таслан сэргийлэх арга хэмжээ гэж “...*эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгаж, хязгаарлалт тогтоох ... арга хэмжээг авах...*” гэж тодорхойлсон байна.

Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд мөрдөх чиг үүргийн байгууллагаас гадна бусад байгууллага оролцох бөгөөд хяналтын төхөөрөмж ашиглах аргаар хэрэгжүүлэхээр заасан, түүнчлэн цагдан хорих арга хэмжээ оногдуулахад гэмт хэргийн ангилал хамаарахгүй бөгөөд гагцхүү цагдан хорих арга хэмжээний нийт

²⁴Шинэчилэн найруулсан ЭХХШТХууль

хугацааг тогтооход гэмт хэрэгт ногдуулах ялын хэмжээ хамаарахаар байгаа нь хохирогчийг хамгаалах чиглэлд ач холбогдолтой байна.

Мөн хуулийн 8.3 дугаар зүйлд “Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авсан, өөрчилсөн, хүчингүй болгосон, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, хаасан, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хэргийг прокурорт шилжүүлсэн талаар мөрдөгч түүнд мэдэгдэнэ.” гэж заасан нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах чухал зохицуулалт болсон байна.

Иймд энэхүү шинэ хуулийн хэрэгжилтийг практикт зөв агуулга, хандлагаар хэрэгжүүлж хэвшүүлэх нь чухал байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ:

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлд гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл хохирол учирсан бол хамгаалуулах эрх үүсэхээр хуульчилсан.

Гэрч, хохирогч нь ЭБШХ, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан эрхээ эдэлж чадахгүй байгаа шалтгаан нь нэг талаас хохирогчийн хууль, эрх зүйн мэдлэг, ойлголттой холбоотой боловч нөгөө талаас хэрэг шалгах ажиллагааг хэрэгжүүлэгч буюу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид нь хохирогчийн эрхийг бүрэн ойлгомжтой хэлбэрээр тайлбарлаж өгөхгүй байх, зөвхөн унших төдийгөөр хязгаарлах, эсхүл тайлбарласан мэтээр тэмдэглэл үйлдэж, гарын үсэг зуруулах зэргээр хохирогчид эрхийг нь тайлбарлах үүргээ хэрэгжүүлдэгтэй холбоотой байна.

Хэдийгээр шинээр үйлчилж эхлээд байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хохирогчийн эрхийг заасан боловч хууль хэрэгжүүлдэг хуучин практик хэвээрээ байгаа нөхцөлд энэ байдал дээрдэхгүй гэдийг мөрдөн байцаах болон прокурорын байгууллага, өмгөөлөгчид анхаарах шаардлагатай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хохирогчийг “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг” гэж тодорхойлсон нь өмнөх хуулийн зохицуулалтаас илүү өргөн боломжийг хамарсан төдийгүй эрхийг нь өргөжүүлж, улмаар эрхийг нь хангах чиглэлд тодорхой зохицуулалтыг тусгасан байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хууль /2002/	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017/
42 дугаар зүйл. Хохирогч 42.3.Хохирогч, түүний төлөөлөгч нь дараахь эрх эдэлнэ:	8.2 дугаар зүйл.Хохирогчийн эрх 1.Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараахь эрхтэй:

<p>42.3.1. өмгөөлөгч авах /энэ заалт нь төлөөлөгч өмгөөлөгчөөр оролцож байгаа тохиолдолд хамаарахгүй/;</p> <p>42.3.2. баримт сэлт гаргаж өгөх;</p> <p>42.3.3. нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;</p> <p>42.3.4. шүүх хуралдаанд оролцох;</p> <p>42.3.5. шүүгдэгч, гэрч, шинжээчид асуулт тавих;</p> <p>42.3.6. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;</p> <p>42.3.7. эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;</p> <p>42.3.8. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцах;</p> <p>42.3.9. гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;</p> <p>42.3.10. цагаатгах буюу шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах;</p> <p>42.3.11. бусад этгээдээс шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэлтэй танилцаж тайлбар гаргах;</p> <p>42.3.12. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах.</p> <p>42.4. Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан, эсхүл эрх зүйн чадамжгүй болсон бол энэ зүйлд заасан эрхийг түүний гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүн эдэлнэ.</p>	<p>1.1. өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах;</p> <p>1.2. хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гаргаж өгч хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах;</p> <p>1.3. мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;</p> <p>1.4. шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцох;</p> <p>1.5. шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр шүүгдэгч, гэрч, шинжээчид асуулт тавих;</p> <p>1.6. шүүх, прокурор, мөрдөгчийн ажиллагаа, шийдвэрт энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах;</p> <p>1.7. эх хэлээрээ, эсхүл сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;</p> <p>1.8. хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй танилцах, нэмэлт ажиллагаа хийлгэх тухай хүсэлт гаргах;</p> <p>1.9. гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;</p> <p>1.10. шүүхийн цагаатгах, шийтгэх тогтоолын хувийг авах;</p> <p>1.11. шүүгч, прокурор, мөрдөгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, мэргэжилтэн, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;</p> <p>1.12. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах;</p> <p>1.13. энэ хуульд заасан бусад эрх.</p> <p>2. Хохирогч нас барсан, эрх зүйн чадамжгүй болсон, эсхүл өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах чадваргүй бол энэ зүйлд заасан эрхийг түүний хууль ёсны төлөөлөгч эдэлнэ.</p>
<p>42.5. Хохирогч нь дараахь үүрэг хүлээнэ :</p> <p>42.5.1. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн дуудсанаар ирэх;</p> <p>42.5.2. хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх;</p> <p>42.5.3. өөрт илэрхий болсон хэргийн талаархи баримт сэлтийг задруулахгүй байх;</p> <p>42.5.4. шүүх хуралдаан болон байцаан шийтгэх ажиллагааны журмыг сахих.</p>	<p>3. Хохирогч дараахь үүрэгтэй:</p> <p>3.1. шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирэх;</p> <p>3.2. хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх;</p> <p>3.3. өөрт илэрхий болсон хэргийн талаархи мэдээллийг задруулахгүй байх;</p> <p>3.4. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам сахих.</p>
<p>42.6. Хохирогч мэдүүлэг өгөхөөс санаатайгаар татгалзсан, зайлсхийсэн,</p>	<p>4. Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, мэдүүлэг өгөхөөс</p>

эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	санаатайгаар зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
--	--

Ийнхүү хохирогчийн эрхийг дэлгэрүүлж зааснаас хохирогчийн мэдээлэл авах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар хуулийн 8.3, 8.4 дүгээр зүйлд тусгайлан зохицуулсан.

Түүнчлэн гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг бие даасан бүлгээр хуульчилж /Арван гуравдугаар бүлэг/ “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн санал, гэрч, хохирогчийн хүсэлтийг үндэслэн прокурор, шүүхийн шатанд прокурорын санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн шүүгч Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх шийдвэр гаргах”-аар заасан байна.

Үүнд :

- 1.1.тодорхой үйлдлийг хязгаарлах;
- 1.2.биечилсэн хамгаалалтад авах;
- 1.3.мэдээллийн нууцлалыг хангах;
- 1.4.нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, холбооны хэрэгслээр хангах арга хэмжээ хамаарахаар байна.

Хуульд зааснаар дээрх хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд

- нийтэд мэдээлэх мэдээллээс гэрч, хохирогчийг танихад ашиглагдаж болох нэр, хаяг, ажлын газар, мэргэжил, бусад баримт мэдээ, мэдээллийг нууцлах, өөрчлөх, арилгах;
- нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчийн талаархи мэдээ, мэдээллийг хайх, задруулахыг хориглох;
- шүүхээс тогтоосон хугацаанд мэдээллийг задруулахыг хориглох;
- гэрч, хохирогчийн нэрийг ил болгон танилцуулах хүртэл гэрч, хохирогчид зохиомол нэр өгч хамгаалах аргыг хэрэглэх боломжтой байна.

Үүнээс гадна тухайн хэргийг гэрчлэхтэй холбоотойгоор гэрч, хохирогч, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд аюул учрах бодит үндэслэл байгаа тухай прокурорын санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл гэрч, хохирогчийг шүүх хуралдааны танхимд байлцуулахгүйгээр харилцаа холбооны хэрэгсэл ашиглан шүүхийн хэлэлцүүлэгт оролцуулах, шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд байгаа үед гэрч, хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзсан, эсхүл түүнийг байлцуулах үед гэрч, хохирогч үнэнийг мэдүүлэхгүй байх нөхцөл байдал

үүсч болохоор бол шүүх хуралдааны танхимаас шүүгдэгчийг түр гаргах арга хэмжээг шүүхээс авч болохоор заасан байна.

Гэвч эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн зарим өөрчлөлт хохирогчдын эрхийг дордуулсан байна. Тухайлбал: Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 12.3 дугаар зүйлд зааснаар зорчих эрхийг нь хязгаарлахгүйгээр ашиг олох зорилгоор насанд хүрээгүй, түүнчлэн бүр бага насны хүнийг бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулах нь хүн худалдаалах гэмт хэрэгт тооцогдохгүй бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт тооцогдохоор байна.

Бэлгийн мөлжлөгт 14-18 насны хүүхдийг ашигласан бол **2-8 жил**, бага насны хүүхдийг ашигласан бол 12-20 жил, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэхээр байна. Гэтэл хүүхэд худалдаалсан бол **5-12 жил** хүртэл хорих ял шийтгэхээр байна.

Насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх замаар биеийг нь үнэлүүлэх нь хүн худалдаалах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж хэмээн үзэж 2012 онд Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан боловч энэхүү Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар энэ зохицуулалтыг эсрэгээр дордуулан, хүүхдийн эрхийн эрсдлийг нэмэгдүүлсэн байна.

Эрүүгийн хууль/Шинэчилсэн найруулга/	
12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг	13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах
<p>1.Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг <u>далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр</u> бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>1.Биеийг нь үнэлүүлэх, <u>бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг</u>, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>
<p>2.Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:</p> <p>2.1.<u>арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүүхдийг</u> албадан оруулж;</p> <p>2.2.урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;</p>	<p>2.Энэ гэмт хэргийг:</p> <p>2.1.<u>хүүхэд</u>, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж;</p> <p>2.2.хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж;</p> <p>2.3.Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол <u>таван жилээс арван хоёр жил</u> хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>

<p>2.3.хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж; 2.4.хохирогчийг жирэмсэн болгож; 2.5.хоёр, түүнээс олон хүний эсрэг; 2.6.байнга тогтвортой үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	
<p>3.Энэ гэмт хэргийн улмаас: 3.1.ураг зулбасан; 3.2.арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>3.Энэ гэмт хэргийг: 3.1.байнга тогтвортой; 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.</p>
<p>4.Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор: 4.1.бага насны хүүхдийг албадан оруулж; 4.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.</p>	
<p>Тайлбар: -Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.</p>	<p>Тайлбар: -Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.</p>

Хэдийгээр хуульд зааснаар хохирогчийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх нь төрийн үүрэг боловч бодит байдалд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх ажлыг ТББ-ууд өөрсдийн нөөц боломжийн хүрээнд хэрэгжүүлж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх улсын харьяаны дагнасан хамгаалах байр байхгүй бөгөөд төрийн бус байгууллагуудын 3 хамгаалах байр ажиллаж байна.

12. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Дэлхийн Улс гүрнүүдэд Хүний наймааны гэмт хэргийн талаар нэгдсэн судалгаа явуулах мэдээлэл хийх олныг хамарсан сурталчилгаа явуулах хүний наймаатай тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх нийгмийн болон эдийн засгийн боломжийг бүрдүүлэх ёстой²⁵ хэмээн заасан байна.

²⁵ Протоколын 9-р зүйлийн 2 дахь заалт

Бүс нутгийн хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд тусгай хөтөлбөр гэрээ байгуулан ажиллаж байгаа улс орон олон байгаа билээ. Ялангуяа Азийн бүсийн улс орнуудын хувьд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нарын тоо бусад тивүүдээс ихээхэн хэмжээтэй байдаг бөгөөд үүнтэй уялдан Азийн тэр дундаа Зүүн Азийн улс орнуудын засгийн газруудад энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд ихээхэн хүч чармайлт гарган ажилласаар байна.

Тайланд, Камбодж, Вьетнам, Бирм, Лаос, улсуудын засгийн газрууд хамтран алдарт Меконгийн гэрээг байгуулан хүний наймааны гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх хохирогч нарыг хамгаалахад хамтран ажиллах зорилготойгоор засгийн газрын түвшинд ажиллаж байна. Индонез, Малайзын засгийн газрын хооронд 2005 онд байгуулсан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хүсээгүй албадан ажил хийлгэх, сексийн зорилгоор цагаач ажилчдыг ажиллуулах зэрэгт хяналт тавин ажиллахаар болсон байна.

Австралийн засгийн газар үндэстэн дамнасан зохион байгуулалтай гэмт хэргийн эсрэг Балигийн үйл ажиллагааг үүсгэн байгуулагч удирдагчдын хувьд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бүсийн хэмжээний төсөв боловсруулах олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх хүчний байгууллагуудад зааварчлагаа өгөх хохирогчдод өгөх тусламжийг сайжруулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна.

Олон улсын хэмжээнд хүн худалдаалах гэмт хэргийг таслан зогсоох, бууруулах, хохирогч хамгаалах, эргэн нийгэмшүүлэх, хэвийн амьдралд буцаан оруулах, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн гэмт хэрэгтэнтэй хатуу тэмцэл өрнүүлэх, тэр дундаа энэ төрлийн гэмт хэргийг үйлдэгч албан тушаалтан төрийн албан хаагч энэ төрлийн гэмт хэрэгт оролцсон буюу үйлдсэн тохиолдолд ял шийтгэлийн бодлого хатуу байлгах тал дээр хүний эрхийн байгууллагууд идэвхтэй ажиллаж байна.

Монгол Улс дахь олон улсын гэрээний хэрэгжилт:

Өнгөрсөн хугацаанд Монгол Улс хүний эрхийн нөхцөл байдлаа НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөр 2 удаа дүгнүүлээд байна.

Монгол Улсын хүний эрхийн анхдугаар нэгдсэн тайлан илтгэлтэй холбогдуулан 2010 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газарт өгсөн 126 зөвлөмжийн²⁶ хүрээнд хүн худалдаалахтай тэмцэх чиглэлд 17 зөвлөмж буюу хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, тэдэнд үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, дотоодын хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах зэрэг зөвлөмжийг тусгайлан өгсөн байна.²⁷

²⁶2014 оны байдлаар 27 зөвлөмж бүрэн хэрэгжсэн, 29 зөвлөмж хэрэгжилтийн түвшинд тодорхой үр дүнг гаргасан, 70 зөвлөмж хэрэгжилтийн шатанд байсан байна.

²⁷НҮБ-ын ХЭХ-ний зөвлөмж. www.upr-mongolia.mn

Харин НҮБ-ын хүний эрхийн зөвлөлийн 22 дахь удаагийн хуралдаан 2015 оны 5 дугаар сард Нью-Йорк хотноо хуралдаж Монгол Улсын Засгийн Газарт 155 зөвлөмж өгч 152 зөвлөмжийг хүлээн авснаас хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдол бүхий 16 зөвлөмж байлаа. Үүнд:

- **5.116, 5.123-д** ЭХ-ийн 113, ХХГХ-т ял оногдуулах,яллах чадавхийг бэхжүүлэх, хууль сахиулах албан хаагчдын үйлдсэн хэргийг оролцуулан ХХГХ-ийг оролцсон байж болзошгүй бүх үйлдлийг мөрдөн шалгах, хохирогчдод нөхөн төлбөр олгох, нөхөн сэргээх зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор хэрэг хянах шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй бүх талд зориулсан сургалт зохион байгуулах;
- **5.117,5.118,5.119** ХХГХ-тэй тэмцэх тухай 2012 оны хуулийг хэрэгжүүлж гэмт этгээдийг мөрдөн шалгах, яллах ажиллагааны үр нөлөөтэй байдлыг хангах, хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх үүднээс хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагыг бэхжүүлэх, ялангуяа эмэгтэйчүүд хүүхдүүдийг худалдаалахтай тэмцэх арга хэмжээг өргөжүүлэх;
- **5.120,5.122** Хүн худалдаалахтай тэмцэхэд шаардлагатай боловсон хүчний болон материаллаг бүх нөөцийг хувиарлан олгох;
- **5.121** ХХГХ-ийн хохирогч, гэрч эрх зүйн туслалцаа хамгаалалт нөхөн сэргээх үйлчилгээ авах боломжоор баталгаатай хангагдах нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай төсвийн, захиргааны болон эрх зүйн арга хэмжээг авах;
- **5.23,5.22** Хүн бүрийн эрх тэгш болон аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин, хүний эрхийн соёлыг бүрдүүлэх үүднээс Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах, эрх зүйн бусад орчноо сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй нааштай ажлаа үргэлжлүүлж, батлагдах хуулиа үр нөлөөтэй хэрэгжүүлэх;
- **5.17, 5.18** Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд үндэсний хууль тогтоомжоо бүрэн нийцүүлэх, Олон улсын эрүүгийн шүүхийн Эрх ямба, дархан эрхийн тухай гэрээг соёрхон батлах;
- **5-128** Насанд хүрээгүй хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх цогц тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн бий болгох;

- **5-113** Хүүхдийн хөдөлмөрийг мөлжиж буй ажил олгогчийн үйлдлийг эрүүгийн хэрэгт тооцох, тэдэнд хариуцлага хүлээлгэх зэргээр хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх;
- **5-111** Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах 2012-2016 оны үйл ажиллагааны үндсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, хөтөлбөр хэрэгжсэний дараах тогтолцоог судлан үзэх;
- **5-108** Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх үр нөлөө бүхий арга хэмжээнүүд авах, хүүхдийг хөдөлмөрийн мөлжлөгт өртөх, ялангуяа хөдөлмөрийн аюултай нөхцөл байдалд ажиллуулах мөлжлөгт өртөхөөс хамгаалах зайлшгүй шаардлагатай гэсэн зөвлөмжийг Монгол Улсын Засгийн Газарт өгчээ.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ЗГ-ын 2016 оны 4 сарын 11-ний өдрийн 204 тоот тогтоолоор 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг батлан гаргасан бөгөөд энэ хүрээнд 8 багц чиглэлд цөөнгүй арга хэмжээг төлөвлөсөн байна.

Зөвлөмж		Төлөвлөгөө	Хэрэгжүүлэгч
1	Шүүх, хууль сахиулах байгууллагын чадавхийг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> ✓ Хуулийн хэрэгжилтийг сайжруулах, 16.5-д заасан журмыг баталж, хэрэгжүүлэх; ✓ Үндэсний хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх; 	<ul style="list-style-type: none"> • ХЗДХЯ • ГХЯ • БСШУЯ • Консулын газрууд
2	ХХГХТТХ-ийн хэрэгжилтийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> ✓ Мэдээллийн нэгдсэн сан байгуулах; ✓ Дэд зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах; 	<ul style="list-style-type: none"> • ЦЕГ • ШШГЕГ • ХХЕГ • ГИХГ
3	ХХГХ-ийн хэлбэрийг ЭХ-д өргөн хамруулах	<ul style="list-style-type: none"> ✓ ТББ-уудын үйл ажиллагааг төрөөс дэмжих; ✓ Хууль сахиулагч болон хуульчдыг бэлтгэх, давтан болон мэргэжлийн сургалтын хөтөлбөрт агуулга суулгах, сургалт зохион байгуулах; 	<ul style="list-style-type: none"> • ШЕЗ • УДШ • УЕП • МХХ • ХСИС
4	ХХГХ-ийг мөрдөн шалгах ажиллагааг сайжруулах	<ul style="list-style-type: none"> ✓ Хамгаалах байрны хэвийн ажиллах санхүүгийн болон бусад нөхцөлийг хангах; 	
5	Хохирогчид үзүүлэх үйлчилгээ, хамгаалалтыг сайжруулах	<ul style="list-style-type: none"> ✓ Олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах; 	

6	Хууль хэрэгжүүлэгч мэргэжилтнүүдийг чадавхижуулах	✓ ОУ-ын хамтын ажиллагааг өргөжүүлэх; ✓ Цагдаагийн мэргэшсэн алба хаагч ажиллуулах; ✓ ХХГХ-ийн шинэ хэлбэрүүдээс урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарах.	
7	Санхүүгийн нөөцийг зөв төсөвлөх, зарцуулах		
8	Иргэдийн ойлголт, хандлагыг сайжруулах		

13.ХЭРЭГЦЭЭГ ҮНЭЛЭХ

Хохирогчийг тогтоох, зуучлан туслах хамгаалахад тулгарч буй бэрхшээлүүд:

Монгол Улс нь хүн худалдаалах гэмт хэргийг Эрүүгийн хуульдаа хуульчлан хориглож, 2012 онд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдын эрхийг хамгаалах зорилго бүхий “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” бие даасан хуулийг батлан хэрэгжүүлж эхлээд 5 жил болж байна.

Гэвч хуулийн хэрэгжилт хангалтгүй, хүн худалдаалах гэмт хэрэг нь ялангуяа хөдөлмөрийн мөлжлөг, охид, эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлэх хэлбэрээр түгээмэл үйлдэгдэж, энэхүү хэрэг нь нууц далд, зохион байгуулалттай, үндэстэн дамнан үйлдэгддэг тул хохирогчийг илрүүлэх, зөв таних ажил сүүлийн 3 жилд хамгийн доод түвшинд хүрээд байна.

Цагдаагийн байгууллагын мэдээллээс үзэхэд жилд энэ төрлийн гэмт хэрэг дунджаар 10 орчим бүртгэгддэг боловч,энэхүү судалгааны хүрээнд хийгдсэн ярилцлагаас дүгнэхэд бодит байдалд энэ гэмт хэргийн гаралт даруй 4-5 дахин их байхаар байна.

Гэтэл хохирогчид үзүүлэх төрөл бүрийн үйлчилгээ болон хохирогчтой ажилладаг ажилтануудын цалин урамшуулалд төрөөс санхүүжилт олгож байгаагүй.

Хүн худалдаалах гэмт хэрэгт хохирогчид энэхүү хэрэгт өртсөнөөсөө болж захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу биеэ үнэлсэн хэргээр торгуулах, 7-30 хоногоор баривчлуулах явдал нэлээдгүй бөгөөд хохирогч хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр авах баталгаа байхгүй байна.

Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас Эрүүгийн хуулийг хэрэглэх, хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, гэмт хэрэгтнийг шийтгэх талаар хуульчдыг мэргэшүүлэх зорилгоор сургалт хийгддэг боловч тогтмол бус, сургалтанд хамрагдсан алба хаагчид байнга солигдож байгаа нь сургалтын үр дүнг бууруулж байна.

Шүүхээр хүн худалдаалах хэргийг зөвхөн бэлгийн мөлжлөг, биеийг нь үнэлүүлж байсан хэлбэрийг шийдэхээс бус хөдөлмөрийн мөлжлөг, боолчлолын хэлбэр, хүүхдээр мал маллуулах, хурдан морь унуулж хөдөлмөрийг мөлжих зэргийг хүн худалдаалах гэмт хэрэг гэж үздэггүй байдал нь энэ гэмт хэргийг даамжруулахад хүргэж байна.

Зохих хэмжээний үйлчилгээ үзүүлдэг нэгдсэн тогтолцоо байхгүй байна.

ХХГХ-тэй тэмцэж буй байгууллагуудын хоорондын уялдаа, холбоо:

Хууль хэрэгжүүлэгч мэргэжилтнүүдийг бэлтгэх ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр нарийвчлан сургах албан ёсны тогтолцоо байхгүйгээс зохион байгуулсан сургалтууд тохиолдлын шинжтэй байна. Тодорхой давтамжтай сургах нэгдсэн бодлого байхгүй байна.

Мөн сургалтын хөтөлбөр, агуулгад тавигдах албан ёсны стандарт байхгүй байна. Үүнээс гадна сургалт нь хамтран ажиллах үүрэг бүхий мэргэжилтнүүдийг бүхэлд нь хамарч чадахгүй, тэднийг хамтран ажиллах арга зүйг олгоход чиглэж чадахгүй байна. Тухайлбал: хуульчдад зориулсан сургалтын агуулгын 80-90%-ийг тухайн төрлийн гэмт хэргийг ЭХ-ийн дагуу хэрхэн зүйлчлэх талаар байна.

Гэтэл хуульчдын гол үүрэг болох хохирогчийн аюулгүй байдлыг хангах, холбогдох үйлчилгээ, дэмжлэгт хэрхэн холбох, түүний онцлогт нийцсэн аргаар хэрхэн ажиллах талаарх ур чадвар, мэдлэг олгох талаарх агуулга бараг хөндөгдөхгүй байна.

Нөгөө талаар хуульчид буюу шүүгч, прокурор, өмгөөлөгчдийг бэлтгэх үргэлжилсэн сургалт тогтмол зохион байгуулагдах боломжтой боловч одоогийн байдлаар жилд 1 удаа буюу 2 цагийн сургалтаар хязгаарлагдаж байна.

Мөн хууль хэрэгжүүлэгч гол субъект болох цагдаагийн алба хаагчдад зориулсан албан ёсны сургалтын хөтөлбөр байхгүй хэвээр байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль хэрэгжиж эхлээд 5 жил гаруй хугацаа өнгөрсөн боловч хуулийн хэрэгжилтийг хариуцсан төрийн байгууллагаас хяналт, үнэлгээ хийсэн тохиолдол байхгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.9-д зааснаар Дэд зөвлөл нь “хохилогчид үзүүлэх халамж, үйлчилгээний стандартын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх” үүрэгтэй боловч өнөөдрийн байдлаар энэ чиглэлээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.

Харин Хүний эрхийн үндэсний комиссоос Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дугаар илтгэлд хөдөлмөрийн мөлжлөгийн талаар тайлан бэлтгэн, УИХ-д танилцуулж байсан бол ТББ-уудаас тус хуулийн хэрэгжилтийн талаар тодорхой чиглэлд хяналт үнэлгээ, дүн шинжилгээ хийж байсан байна.

Тухайлбал, 2014 онд Хүний наймааны эсрэг ТББ-уудын сүлжээний ажлын хүрээнд Эмэгтэй удирдагч сангаас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд мониторинг, 2015 онд Хүний эрх, хөгжил төвөөс Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан болон батлах шаардлагатай байгаа журмуудад дүн шинжилгээ хийжээ. 2016 онд Хүйсийн тэгш эрхийн төвөөс хийсэн “Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны өртөг” зэрэг үнэлгээг дурьдаж болох юм.

14. ЗӨВЛӨМЖ.

Урьдчилан сэргийлэх ба мэдлэг нэмэгдүүлэх:

1. ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх үүрэг хүлээсэн байгууллагуудын дунд мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгож, мэдээлэл, дүн шинжилгээнд үндэслэн шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх;
2. ХХГХ-тэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг бодитой төлөвлөн тусгах. Арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг улсын болон орон нутгийн төсөвт суулгах;
3. Хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэрээр үйлдэгдэх ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх чиглэлд анхаарал хандуулж, тусгай арга хэмжээ авах;
4. ХХГХ-ийн улмаас аюул занал тулгарсан хохирогчдыг байрлуулах зорилго бүхий хамгаалах байруудын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зардлыг Нийгмийн халамжийн сангаас тусгайлан санхүүжүүлэх;
5. Хуулиар үүрэг хүлээсэн хуульчдыг бэлтгэх, давтан сургах хөтөлбөрт хүн худалдаалах гэмт хэргийг хэргийг шийдвэрлэх мэдлэг олгох агуулга

оруулах. Хуульчдыг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг дан ганц энэ төрлийн гэмт хэргийг хэрхэн зүйлчлэхэд бус хохирогчийг таньж мэдэх, тэдний онцлогийг ойлгох, хуульд заасан үйлчилгээ дэмжлэгтэй холбох чадварыг олгоход анхаарах;

6. Мэдээлэл авч чадахгүй хүн амын бүлэг буюу ядуу, орлого багатай болон орон нутгаас шилжин суурьшигчид, бичиг үсэг тайлагдаагүй болон хүүхэд, залуучуудад зориулагдсан урвдчилан сэргийлэх үйл ажиллагааг төрөлжүүлэн зохион байгуулах, арга хэмжээг тогтмолжуулах;

Хууль хэрэгжүүлэхэд анхаарч сайжруулах зүйлүүд:

1. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулахын зэрэгцээ холбогдох бусад хууль хоорондын зөрчилдөөнийг арилгах. Энэ хүрээнд хохирогчийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд бусад хуулийн зохицуулалтаар давхар хангагдах боломжийг бүрдүүлэх, журмуудыг бүрэн батлах, нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах;
2. ХХГХ-тэй тэмцэхэд мэргэшсэн мөрдөн байцаагч, прокурор, шүүгч ажиллуулахад анхаарах;
3. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх Дэд зөвлөл нь жил тутам ХХГХ-ийн нөхцөл байдлын талаар илтгэл гаргаж байх засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлж, цаашид хэрэгжилтийг сайжруулах чиглэлд зөвлөмж гаргуулах;
4. Гадаад улсуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийг дүгнэн нөхцөл байдлыг зөв тодорхойлж цаашид хамтран ажиллах гарцаа тогтмол шинэчилэх, Монгол Улсын иргэд ихээр зорчих болсон, мөн хил дамжуулан худалдаалах гэмт хэрэг ихээр гардаг Малайз, Сингапур, Хонконг, Тайланд, Филиппин, Макао зэрэг улс орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах талаар Засгийн газар санаачлага гарган ажиллах;
5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх Дэд зөвлөл нь НҮБ-ын зөвлөмжүүд болон ОУ-ын тайлан, илтгэлүүдийн зөвлөмжид заасан хүн худалдаалахтай тэмцэх чиглэлийн арга хэмжээний төлөвлөгөөний

бодит хэрэгжилтэд анхаарч, салбар хоорондын уялдааг хангах, зохион байгуулалтыг хангаж ажиллах

Хохирогчид үйлчилгээ үзүүлэх, хамгаалах:

Хохирогчид нөхөн төлбөр олгох асуудлыг хуульчилсан хуулиудад заасан хохирогч хүнд гэмтэл, амь насаа алдсанаас бусад тохиолдолд нөхөн төлбөр авах боломжгүй байдлыг өөрчилж, сэтгэл санааны дарамт, өөрчлөлтөд орох, бэлгийн замын халдварт өвчин халдах, ажил хөдөлмөрөө хэвийн үргэлжүүлэх боломжгүй болох, гэрлэлтээ цуцлуулахад хүрэх, сургуульд сурах зэрэг боломжоо алдсан гэх мэт нөхцөлийг хамруулан өргөжүүлж, улмаар шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд бус ХХГХ-ийн хохирогчоор тогтоогдсон үеэс буюу мөрдөн байцаалтын шатнаас авах боломжтой болгон хуульчлах;

Төрөөс ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах байр байгуулах, хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нэгдсэн стандартыг хэрэгжүүлэхэд анхаарах; ХХГХ-тэй тэмцэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулиудыг даган гарсан журмуудын хэрэгжилтийг дүгнэх, тус журмуудын хэрэгжилт болон санхүүжилтийн тайланг гаргаж, олон нийтэд мэдээлэх.

15. ДҮГНЭЛТ:

Монгол Улс нь хүн худалдаалах гэмт хэргийг Эрүүгийн хуульдаа хуульчлан хориглож, 2012 онд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдын эрхийг хамгаалах зорилго бүхий “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” бие даасан хуулийг батлан хэрэгжүүлж эхлээд байна.

Гэвч хуулийн хэрэгжилт хангалтгүй, хүн худалдаалах гэмт хэрэг нь ялангуяа хөдөлмөрийн мөлжлөг, охид, эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлэх хэлбэрээр түгээмэл үйлдэгдэж, энэхүү хэрэг нь нууц далд, зохион байгуулалттай, үндэстэн дамнан үйлдэгддэг тул хохирогчийг илрүүлэх, зөв таних ажил хангалтгүй түвшинд байна.

Цагдаагийн байгууллагын мэдээллээс үзэхэд жилд энэ төрлийн гэмт хэрэг дунджаар 10 орчим бүртгэгддэг боловч, энэхүү судалгааны хүрээнд хийгдсэн ярилцлагаас дүгнэхэд бодит байдалд энэ гэмт хэргийн гаралт даруй 4-5 дахин их байхаар байна.

Эрүүгийн цагдаагийн газрын мэдээллээр 2014 оноос хойш гарсан ХХГХ-ийн нийт хохирогчдын 46% нь насанд хүрээгүй хүүхэд байна. Хохирогч хүүхдийн онцлог

хэрэгцээг харгалзсан үйлчилгээ бий болгох энэ төрлийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчдод туслалцаа үзүүлэх сэтгэл зүйч, хуульчдыг бэлтгэх шаардлагатай.

Өнөөг болтол ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлэх төрийн байгууллагын харьяаны дагнасан хамгаалах байр байхгүй байна. Төрийн бус байгууллагуудын 2-3 хамгаалах байр ажиллаж байгаа ч улсын төсвөөс зөвхөн байрны урсгал зардлыг 2013 - 2014 онд Хүйсийн тэгш эрхийн төвийн хамгаалах байранд санхүүжилт өгсөн байна²⁸. Гэтэл ТББ-ын хүн хүчний зардал, үйл ажиллагаа, захиргааны зардал, үйлчилгээний зардалд төрөөс санхүүжилт олгож байгаагүй ажээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч энэхүү хэрэгт өртсөнөөсөө болж биеэ үнэлсэн хэргээр захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу торгуулах, 7-30 хоногоор баривчлуулах явдал нэлээдгүй бөгөөд хохирогч хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр авах баталгаа байхгүй байна.

Жишээлбэл, 2014-2016 онд шүүхээр шийдвэрлэгдсэн 6 хэргээс үзэхэд хохирогчид нийт 190 сая гаруй төгрөгний хохирол нэхэмжилсэн ч зөвхөн эрүүл мэнд, унаа, зайлшгүй тохиолдолд хоол, зочид буудлын зардлыг хохиролд тооцон, нэхэмжлэлийн 6% буюу 11 сая орчим төгрөгийн нэхэмжлэлийг шүүх хангасан шийдвэр гаргасан байна²⁹.

Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас Эрүүгийн хуулийг хэрэглэх, ХХГХ-ийг мөрдөн шалгах, гэмт хэрэгтнийг шийтгэх талаар хуульчдыг мэргэшүүлэх зорилго бүхий сургалт хийдэг боловч тогтмол бус, сургалтанд хамрагдсан албан хаагчид байнга солигдож байгаа нь сургалтын үр дүнг бууруулж байна.

Хууль хяналтын байгууллага хүн худалдаалах хэргийн зөвхөн бэлгийн мөлжлөг, биеийг нь үнэлүүлж байсан хэлбэрийг шийдэхээс бус хөдөлмөрийн мөлжлөг, боолчлолын хэлбэр болох хүүхдээр мал маллуулах, хурдан морь унуулж хөдөлмөрийг мөлжих зэргийг хүн худалдаалах гэмт хэрэг гэж үзэхгүй байгаа нь энэ гэмт хэргийг даамжруулахад хүргэж байна.

²⁸ АНУ-ын Төрийн Департаментас гаргасан “Хүний наймаа” илтгэл, 2016, <https://www.state.gov/documents/organization/258880.pdf>

²⁹ Тодорхой төрлийн гэмт хэрэг: Хүн худалдаалах гэмт хэргийн зардлын талаархи судалгаа. Хүйсийн тэгш эрхийн төв, 2016 он.